

Худалдан авч болох ба болохгүй хүнс

Бие организм санамсаргүйгээр сахар болон давсны илүүдэлд орчихдог. >4

Арын албаны ажилсаг хүн

Палкатны үзгээр бичиж, ямбуун дээр бийрээр зурдаг байлаа. >7

"Саадаг" сангуудыг цэгцлэх шаардлага

Өнөөдрийн байдлаар 20 тусгай сан үйл ажиллагаа явуулж байна. >11



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.03.29, ЛХАГВА ~ №057 (603)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

УИХ-ын хаврын чуулганыг ирэх долоо хоногийн лхагва гарагт нээн.
Иргэнд 2017 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг Засгийн газар хэлэлцэнэ.
АН-ын дотоод сонгуульд өрсөлдөгчид сонгогчдын эрхийг хамгаалахыг хүслээ.
Монголын хүний төлөө намыг Улсын дээд шүүх бүртгэсэн бөгөөд 25 дахь нам болов.
Монгол Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан болж байна.

ЭДИЙН ЗАСАГ

Гадаад валютын дуудлага худалдаанд Монголбанк оролцсонгүй.
"Адуунчулуу" хувьцаат компани нийт 378.1 сая төгрөгийн ногдол ашиг тараана.
Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.06 их наяд төгрөгт хүрч, нийт зээлдэгч нь 89.8 мянгад хүрэв.
"Аймгуудын өрсөлдөх чадварын 2016 оны тайлан"-г ирэх сард танилцуулна.
Хайгуулын салбарт жилдээ хоёр тэрбум ам.доллар татах бололцоотой гэв.

НИЙГЭМ

Хотын дарга дүүргүүдийн удирдлагад иргэдийн шаардлагыг биелүүлэхийг үүрэгдэв.
Өмнөд Суданд үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчид 30 хүнийг халдлагаас аварчээ.
ХХЕГ-ын офицер охидыг хуурч хүчирхийлдэг байсныг ЭЦГ-ынхан илрүүлэв.
Боловсролын үйлчилгээнд авлига газар авсныг судалгаагаар тогтоосон байна.
Сэлэнгэ аймагт энэ сарын 27-нд дөрвөн магнитудын хүчтэй газар хөдөлжээ.

ДЭЛХИЙ

НҮБ-ын цөмийн зэвсгийг хориглох хэлэлцээрт АНУ тэргүүтэй 40 улс оролцохгүй.
Европын томоохон банкууд ашгийнхаа 25 хувийг оффшор бүсээс олсон гэж үзжээ.
АНУ-ын 15 компанид шууд болон шууд бус хориг тавьснаа Тегеран мэдэгдлээ.
Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын хиймэл арлууд удахгүй "сүндэрлэнэ" гэв.
Жаред Кушнер ОХУ болон Д.Трампын холбооны талаар Конгресст тайлбар өгнө.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.03.29



5° | -6°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИЙГ МЭДЭЭЛЭЙГ 8 ДУГААР НУУГУУС ҮНШВЭН ҮҮ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Цэцэрлэгт хүрээлэн бус хар зах



Зорилт, зохион байгуулалт хоёр алд дэлэм зөрсөөр ирлээ. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын цэцэрлэгт хүрээлэн манайхаас хавь илүү сайхан. >5

Б.Ганбаяр/ЗГМ©



ХААН БАНКНЫ CITY PASS КАРТААРАА АВТОБУСАНД ЗОРЧООРОЙ

Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах, цахим картыг хэрэглээнд бүрэн шилжүүлэх, үйлчилгээг шинэ түвшинд гаргах зорилгоор үйлчилгээнд явж буй автобуснуудын бэлэн мөнгөний хайрцагийг хурааж, 04-р сарын 01-ний өдрөөс эхлэн зөвхөн картаар зорчуулах болсон.

Энэ ажлын угтан ХААН Банк иргэд, харилцагчиддаа зориулан нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжтой төлбөрийн болон нийтийн тээврийн хосолсон City Pass картыг Монгол Улсад анхлан гаргаж, үйлчилгээнд нэвтрүүлсэн билээ.

City Pass картыг ашигласнаар:

- Автобусанд үйлчлүүлэхээс гадна банкны төлбөрийн картын зориулалтаар ашиглаж, банкны картаар авдаг бүхий л үйлчилгээг авах
- Иргэд өөрийн ашигладаг харилцах, цалингийн дансандаа автобусны картаа захиалах

City Pass карт нь таны нэр дээрх банкны данстай холбогдох тул та картаа заавал урьдчилан цэнэглэх шаардлагагүй хэрэгцээ шаардлага гарсан үедээ:

- Интернэт банк,
- Ухаалаг банк,
- Мобайл банк,
- АТМ ашиглан дансандаа орлого хийж, нийтийн тээврээр үйлчлүүлэх боломжтой.



CITY PASS КАРТ

БАНК + НИЙТИЙН ТЭЭВЭР ХОСОЛСОН

Та City Pass картыг өөрт ойр байрлах ХААН банкны салбарт хандан аваарай.

Харилцагчийн мэдээллийн төв 1800-1917 | www.khanbank.com | khanbank.com/facebook | khanbank.com/twitter

УЛСТӨР

Япон улсаас 850 сая ам.долларын зээл авна

Т.Элиса
ЗГМ

УИХ-ын дарга М.Энхболдын Япон улсад хийж буй албан ёсны айлчлал үргэлжилж байна. Япон улс Монгол Улсад ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 850 сая ам.долларын нэн хөнгөлөлттэй зээл олгохоор боллоо. Жилийн 1-1.5 хувийн хүүтэй уг зээлийн эхний 10 жилийн хүүгийн төлбөрийг чөлөөлөхөөр тохирчээ.

Энэ нь Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш тус улсаас манай улсад олгосон нэн хөнгөлөлттэй зээлийн дүнтэй бараг дүйж байгаа аж. Тус улсаас Монгол Улсад гурван тэрбум ам.долларын зээл олгосны нэг тэрбум

ам.доллар нь нэн хөнгөлөлттэй зээл байжээ. Мөн УИХ-ын дарга айлчлалынхаа хүрээнд Япон-Монголын найрамдлын нийгэмлэгийн удирдлагуудын зохион байгуулсан хүндэтгэлийн арга хэмжээнд оролцлоо.

Энэ үеэр Монгол Улс уул уурхайгаас гадна ямар салбарт тулхүү анхаарч байгаа болон долоо хоногт гурван удаагийн нислэг үйлддэг ч хоёр талын аль алинд нь суудал олдохгүй байгаа тул МИАТ компани Токио, Улаанбаатар хоорондын нислэгийнхээ тоог нэмэх боломж байгаа эсэх талаар сонирхов. Өөрөөр хэлбэл, Японы хөрөнгө оруулагчид Монголыг сонирхож эхэлжээ.

>2

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Хавар ирлээ, каскаа бэлдээрэй

Өнгөрсөн онд үйлдвэрлэлийн ослоор 31 монгол хүн амиа алдсан гэж харамсаар мэдээлэл байна. Үүнээс өмнө буюу 2015 онд түүнээс ч олон хүн амиа алдсан гэж тооцвол, сүүлийн хоёр жилд үйлдвэрлэлийн ослоор нийт 100 орчим элэг нэгтэн нас баржээ. Харин хугацааг нь гурван жилээр сунгавал, сүүлийн таван жилд 300-гаар тоологдох хүн эрдэнэт амиа алдсан байх юм.

Г.Байгал
@baigalZGM

Аюул хаана ч тохиолдож болзошгүй. Иймд анхаарлаа дээд цэгт нь "асаагаарай". Учир нь хавар аминд халтай улирал болохоо хангалттай харуулсан. Уурхай үүдээ нээж, өндөр барилгууд өндийдөг урин цагт үйлдвэрлэлийн осол өсдөг нь үнэн.

Тоон статистик рүү өнгийвөл,

өнгөрсөн онд үйлдвэрлэлийн ослоор 31 монгол хүн амиа алдсан гэж харамсаар мэдээлэл байна. Үүнээс өмнө буюу 2015 онд түүнээс ч олон хүн амиа алдсан гэж тооцвол, сүүлийн хоёр жилд үйлдвэрлэлийн ослоор нийт 100 орчим элэг нэгтэн нас баржээ. Харин хугацааг нь гурван жилээр сунгавал, сүүлийн таван жилд 300-гаар тоологдох хүн эрдэнэт амиа алдсан байх юм.

Угтаа энэ хэдэн жилүүдэд олон нийтийг айдаст автуулсан аймшигт ослоор ар араасаа гарч, нийгэмд аюулын харанга дэгдээсэн. Барилгын дэврээс бэхлэгээний төмөр унаж, замын хөдөлгөөнд оролцож байсан жолоочийн амь насанд хүрлээ.

>3

MSE ALL

817.14
0.32%

АЛТ

1253.60
0.02%

ЗЭС

5760
0.76%

10-ЧИНГИС БОНД

99.950
0.04%

5-ЧИНГИС БОНД

94.510
0.04%

АМ.ДОЛЛАР

2456.03

ЮАНЬ

356.74


РУБЛЬ

43.15

Улс төр

АЙЛЧЛАЛ

Япон улсаас 850 сая ам.долларын зээл авна



Японоос Монголд нэн хөнгөлөлттэй санхүүгийн зээл олгохоор шийдвэрлэсэнд талархлаа илэрхийлэв.

Токио, Улаанбаатар хоорондын нислэгийн тоог нэмэхийг хүсэв

Харин УИХ-ын дарга М.Энхболд энэ удаагийн айлчлалын хүрээнд хоёр орны Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Японы талын дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгааг онцлов. Уг хөтөлбөрийн эхний хэсгийг 2013-2017 онд хэрэгжүүлсэн юм. Энэ хугацаанд хийсэн хамгийн том ажил бол Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгон хэрэгжүүлж эхэлсэн явдал. Харин энэ удаагийн айлчлалаар Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрт гарын үсэг зурна. 2021 он хүртэлх

хамтын ажиллагааны гол зорилт, зарчмуудыг тодорхойлох энэ хүү баримт бичгийн хүрээнд хамтын ажиллагаа улам өргөжин гүнзгийрнэ гэдэгт итгэлтэй байгаагаа УИХ-ын дарга М.Энхболд илэрхийлсэн.

Өнгөрсөн оны зургадугаар сард Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болж, хэрэгжүүлж эхэлснээс хойш хоёрдугаар сарын байдлаар нийт 320 ширхэг 8.2 сая ам.долларын үнэ бүхий Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гаалийн тарифын хөнгөлөлттэй нөхцөлөөр Япон улсад экспортолсон тухай МҮХАҮТ-аас мэдээллээ. Мөн 300 гаруй бараа, бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгоод байгаа аж. Хэдийгээр ийнхүү хоёр улсын худалдаа өргөжихөд ахиц гарч байгаа ч дутагдалтай тал бас байгаа гэдгийг Япон улсаас Монгол Улсад суусан Элчин сайд асан Такэнори Шимизу онцлоо.

Үргэлжлүүлэн, Япон улсын парламентын Төлөөлөгчдийн

Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр 2021 он хүртэлх хамтын ажиллагааны гол зорилт, зарчмуудыг тодорхойлно.

8.2 сая ам.долларын үнэ бүхий Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Япон улсад экспортолжээ.

Монгол Улстай харилцаатай 100 гаруй нийгэмлэг, төрийн бус байгууллага Японд үйл ажиллагаа явуулдаг ажээ.

танхимын дарга Т.Оошима, Зөвлөхүүдийн танхимын дарга Ч.Датэ нартай уулзлаа. Уулзалтын үеэр УИХ-ын дарга М.Энхболд хоёр орны худалдаа, эдийн засгийн болон бусад салбарын хамтын ажиллагаа амжилттай хөгжихөд хууль

эрх зүйн таатай орчин чухал. Тиймээс парламентын гишүүдийг харилцан айлчлуулж туршлага, хуваалцаа, парламент дахь бүлгүүд болон Тамгын газруудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь бидний бас нэг гол зорилго байх ёстой гэв. Мөн өдгөө Монгол Улсад тохиооод буй эдийн засаг, санхүүгийн бэрхшээлийг даван туулах, ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахад ч Япон улс хүчин чармайлт гаргасныг тэмдэглэж, энэ хөтөлбөрийн хүрээнд Японоос Монголд нэн хөнгөлөлттэй санхүүгийн зээл олгохоор шийдвэрлэсэнд талархлаа илэрхийлэв.

Дашрамд дурдахад, Монгол Улстай харилцаатай 100 гаруй нийгэмлэг, төрийн бус байгууллага Японд үйл ажиллагаа явуулдаг ажээ. Тэдгээрээс анхных нь Япон-Монголын нийгэмлэг бөгөөд Дэлхийн II дайны дараа манай улсад олзонд байгаад нутаг буцсан япон иргэдийн санаачилгаар 1959

онд байгуулж, Засгийн газар нь 1964 онд тус нийгэмлэгийн үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрчээ. Хоёр дахь нь энэ жил 50 жилийн ойгоо тэмдэглэж буй Япон-Монголын найрамдлын нийгэмлэг юм. Япон-Монголын эв найрамдлын нийгэмлэгийг 1991 онд байгуулж, 1993 онд тухайн үеийн Ерөнхий сайд асан Т.Кайфү тус нийгэмлэгийн даргаар сонгогдож байсан байна. Одоо нийгэмлэгийн хүндэт зөвлөхөөр Ерөнхий сайд асан Я.Накасонэ ажилладаг. 1991 онд байгуулсан Япон-Монголын эмэгтэйчүүдийн соёлын солилцооны “Солонго” нийгэмлэгийн тэргүүн нь хатагтай К.Фүжimoto юм. Тэрбээр 1991-2003 онд 1.7 сая ширхэг саван цуглуулж Монголын эхчүүд, эмэгтэйчүүд хандивлаж байсан бөгөөд Улаанбаатар хотод “Солонго” дунд сургууль байгуулж, эхчүүд хүүхдүүдийн сайн сайханд чиглэсэн олон ажил зохион байгуулжээ. [ЗГМ]

ТОВЧХОН

» ПАРЛАМЕНТ
Хуульд заасны дагуу УИХ-ын хаврын чуулган ирэх долоо хоногийн лхагва гарагт нээлтээ хийнэ. Хаврын чуулганы эхэнд Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцэх юм. 2017 оны төсөвт тодотгол хийж чадвал Монгол Улс ОУВС-д хамрагдах боломж бүрдэх юм.

» УУЛЗАЛТ
Монгол, Хятад, Оросын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талын экспертүүдийн анхдугаар уулзалт БНХАУ-ын Бээжин хотноо боллоо. Уулзалтаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим, арга замын талаар санал солилцжээ. Мөн хөтөлбөрийн хүрээнд цаашид авах арга хэмжээ болон тохиролцсон асуудлаар протокол байгуулав.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА
Монгол Улсаас Бүгд Найрамдах Мальта улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ц.Жамбалдорж тус улсын Ерөнхийлөгч Мари-Луиз Колейро Прекад итгэмжлэх жуух бичгээ барив.

» НАМУУД
Ардчилсан намын дотоод сонгуулийн санал хураалт ирэх ням гарагт болно. Энэ удаагийн сонгуулиар Үндэсний бодлогын хорооны 380 гишүүн, мөн аймаг, нийслэл, дүүргийн намын хороодын дарга нарыг нийт гишүүнийхээ санал хураалтаар сонгох юм. Сонгуульд тус намын 152800 гишүүн саналаа өгөх аж.

» ТОО

30

Хувь. Төрийн албанд нийт 186458 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 19687 нь буюу 10.56 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 35736 буюу 19.17 хувь нь төрийн тусгай албан хаагч байна. Мөн 127943 нь буюу 68.61 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 3092 буюу 1.66 хувь нь төрийн улс төрийн албан хаагч аж. Төрийн нийт албан хаагчийн 30 орчим хувийг төрийн жинхэнэ албан хаагч эзэлж байна.

» ШИЙДВЭР
Монголын хүний төлөө намыг улсын бүртгэлд бүртгэх шийдвэрийг Улсын дээд шүүхээс гаргалаа. Ингэснээр Монголын хүний төлөө нам нь улсын бүртгэлд бүртгэлтэй 25 дахь улс төрийн хүчин болов.

» СОНГОЛТ-2017
Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтыг ирэх зургадугаар сарын 26-ны өдөр явуулахаар болсон. Үүнтэй холбогдуулан Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгогчдын нэрийн жагсаалтыг <https://burtgel.gov.mn> цахим хуудсанд байршуулсан. Энэхүү жагсаалтад иргэд өөрийн нэр, холбогдох мэдээлэл байгаа, эсэхээ <https://burtgel.mn> хаягаар орж шалгах боломжтой аж.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ТӨСӨЛ

Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэх шаардлагатай гэв

2008-2016 онд ирсэн нийт гомдлын 27 хувь нь ажлаас халагдсан.



Б.Тогтох
ЗГМ

Хуульд заасны дагуу жил бүрийн эхний улиралд багтаан Хүний эрхийн үндэсний комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг УИХ-д өргөн мэдүүлдэг билээ. Хүний эрхийн үндэсний комисс нь 16 дахь илтгэлээ өөрсдийн хийсэн хяналт шалгалт, судалгаа, иргэдээс комисст гаргасан өргөдөл гомдол, комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд тулгуурлан боловсруулжээ. Мөн уг илтгэлд иргэний нийгмийн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, дүн шинжилгээ, Засгийн газар, яам, агентлаг болон бусад байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг тусгасан байна.

Энэхүү илтгэл нь УИХ, Засгийн газар, түүний харьяа байгууллага, олон нийтийн анхаарлыг хүний эрхийн тул-

гамдсан асуудалд хандуулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, эрхийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор бодлогын түвшинд өөрчлөлт хийхэд чиглэсэн баримт бичиг юм.

Энэ удаагийн илтгэлд хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал, хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал болон цэргийн алба хаагч, ажилтны хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаар тусгасан байна. Мөн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаарх тайланг гаргажээ.

Тодруулбал, нийгэм хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй энэ цаг үед хүүхэд гэвчигшгүй хөдөлмөр эрхлэх, цахим орчинд донтох, мөн бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийлэлд өртөх тохиолдол гарсаар байна. Иймд хүүхдийн

эрхийн эдгээр зөрчлийг арилгахын тулд дан ганц хууль эрх зүйн орчныг сайжруулах нь хангалтгүй юм. Хүүхэд, насанд хүрэгчид, үүрэг хүлээгчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нийгмийн тогтсон хандлагыг өөрчлөх шаардлагатай гэж үзжээ.

Мөн сүүлийн жилүүдэд комисст ирүүлсэн өргөдөл гомдол, хууль зүйн зөвлөгөөний 30 орчим хувийг хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудал эзэлж байгаа аж. Тухайлбал, 2008-2016 онд ирсэн нийт гомдлын 27 хувь нь ажлаас халагдсан, 14 хувь нь ажилд эгүүлэн томилохтой холбоотой шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа, зургаан хувь нь ажилд эргүүлэн томилох шүүхийн шийдвэр биелсэн ч дахин ажлаас халагдсан тухай тус тус эзэлж байна.

Иймд Хөдөлмөрийн тухай хуулийг зах зээлийн өнөөгийн нөхцөл шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах хэрэгтэй гэж үзжээ. [ЗГМ]

ЭШЛЭЛ

-Хууль зүйн талаасаа УИХ-ын нийт гишүүний дөрөвний гурван хувь нь дэмжиж байж Үндсэн хуулийг өөрчилнө. Тиймээс нэг нам, улс төрийн хүчин хэт олонх суудалтай, эсэхээс үл хамаарч Үндсэн хууль нэмэлт өөрчлөлт оруулах эрх зүйн орчин бол байна. Нөгөөтэйгүүр Үндсэн хуульд нь хууль зүйн баримт бичиг байхаас гадна улс төр, нийгмийн зөвшилцлийн баримт бичиг. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа улс төрийн хүчин, иргэний нийгмийн байгууллага, өргөн олон иргэдийн оролцоог хангах, нийгэм даяараа зөвшилцөл хийх шаардлага байгаа. Үндсэн хуульд байнга гар хүрээд байх боломж хомс учраас одоо нэгэнт ийм яриа эхэлсэн учраас олон удаагийн хэлэлцүүлэг хийж, зөвшилцөлд хүрэх бүх арга замыг хайж, оролдох ёстой. Харилцан ойлголцол, бие биенээ хүндэтгэх байдал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажилд маш их хэрэгтэй гэж бодож байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн
Д.Ганзориг

-Эрүүл мэндийн салбарын барилга, их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт жилээс жилд буурч байна. Тухайлбал, 2015 онд 93.5 тэрбум байсан бол энэ онд 35.9 тэрбум төгрөг болж буурсан. Улс орны эдийн засаг хүндхэн байгаа хэдий ч бид мөнгөгүй гээд гараа эвхээд суухгүй бүх боломж гарцыг хайж ажиллаж байна. Яармагийн дэнжид байгаа 300 ортой төрөх эмнэлгийг барьж дуусган ашиглалтад оруулах нөхцөлтэйгөөр концессийн гэрээгээр гүйцэтгүүлнэ. Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын тендерийг шалгаруулах зэрэг ажлыг хийж байна. Цаашид Чингэлтэй дүүрэг, Ховд аймагт загвар нэгдсэн эмнэлгийн барилга, нийслэл хотын дөрвөн өрхийн, зургаан сумын эмнэлгийн барилгыг барих ажлыг Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын төсөв 2016 онд 691.1 тэрбум төгрөг байсан бол энэ онд 659.4 тэрбум төгрөг болж буурсан. Эрүүл мэндийн сайд
А.Цогцэцэг

Нийтлэлчийн булан

Халамжид халхлагдан хөдөлмөрийн бодлого хэрхэн хаягдаж буйн баталгаа энэ

Барилгын тоног төхөөрөмж нурж унаж хүн гэмтээсэн гээд хөдөлмөр хамгааллын бодит байдлыг илчилсэн ослоуд цөөнгүй бий. Гэвч ийнхүү анхаарлын дохио, аюулын сэрэмж өгсөөр байхад үйлдвэрлэлийн осол дорвитой буураагүй л байна. Монголчууд хүний амины үнээр барилга сүндэрлүүлж, үйлдвэрлэл эрхэлсээр.

Ингээд зогсохгүй үйлдвэрлэлийн ослоор гэмтэж бэртсэн хүний тоо ч өндөр хэвээр. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдэлснээр өнгөрсөн онд нийт 332 хүн үйлдвэрлэлийн осол,

оноос тав дахь хөтөлбөрийг эхлүүлэхээр байсан ч өнөө хэр хэлэлцээний шатандаа явааг албаны хүн хэлж байна. Гэвч гацчихаад байгаа хөтөлбөрийг бүтээн байгуулалтын улирал хүлээсэнгүй. Хэзээ мөдгүй өрнүүн ажил ундрах гэж буй.

Тэрчлэн жил бүрийн дөрөвдүгээр сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар болгодог. Энэ онд ч эхлүүлэхээр төлөвлөсөн. Гэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг сурталчилан таниулахаас хэтэрдэггүй энэ аяны зардал, мөнгө нь даржин. Гадаадын төсөл, хөтөлбөр болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас (ҮОМШӨДС) бага хэмжээний санхүүжилт ирдэг байна.

Угтаа дэлхий даяар хөдөлмөрөөс үүдэлтэй осол гэмтлийг бууруулахад урьдчилсан сэргийлэхийг урьтал болгодог. Үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх нь зардал бус хөрөнгө оруулалт гэсэн зарчмыг өндөр хөгжилтэй



Б.Ганбаяр / ЗГМ©

Хавар ирлээ, каскаа бэлдээрэй

хурц хордлогод өртгэж. Хамгийн халагламаар нь, үүний тал нь буюу 159 нь хүнд хэлбэрийнх. Цаашлаад дийлэнх нь цэл залуу, ид хүйс бүтээх насандаа яваа залуу.

Ерөөс элдэв тайлбар, шалтгагүй манай хөдөлмөр хамгааллын бодит төрх энэ. Харуусал дагуулсан эдгээр тоо хөдөлмөр хамгаалал хаана явааг тодорхой хэлээд өгнө. Уг нь албаныхан хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах сарын аян, жилийн ажил сүртэй гэгч нь зарладаг. Холбогдох байгууллагууд ч сарын аянаа хэдийн зарчлахаар. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулахаар төлөвлөсөн. Гэвч сүржин ажлын үр дүн нь даржин. Дуулиант ослоуд нийгэмд шуугиан тарьдаг ч хоног өдөр өнгөрөхийн хэрээр нийгмийг цочроосон үзэгдлүүд мартагдаж, замхарсаар байна. Барилга дээрээс хүн унаж амиа алдах нь одоо энгийн үзэгдэл мэт болжээ. Осол дасал болсон нь энэ. Аливаа аян, ажлыг шүүмжлэх гэсэнгүй. Гагцхүү төрийн бодлогын үр дүнг амиа алдсан монгол хүн, хөдөлмөрийн чадвараа алдсан цэл залуу иргэний тооноос харж болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах чиглэлээр үе үеийн Засгийн газар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ирсэн. Үе шаттай хэрэгжүүлсэн дөрөв дэх хөтөлбөр өнгөрсөн онд эцэслэсэн болохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас мэдээллээ. Уг нь энэ

орнууд баримталдаг болохыг Фридрих Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Штефан Хробот хэлж байна. Бас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд зарцуулсан нэг ам.доллар дөрөв болж, өсдөг гэсэн судалгаа ч бий. Учир нь аюулгүй ажиллагааг эрхэмлэсэнээр бүтээж өсөж, ослын зардал буурдаг зүй тогтолтой аж.

Сүүлийн таван жилд 300-гаар тоологдох хүн амиа алдсан байна

Манай улсад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйгаа хамгаалуулахын тулд иргэд, аж ахуйн нэгжүүд төрд мөнгө төрдөг. Аж ахуйн нэгжүүд орлогынхоо тодорхой хувийг шимтгэл хэлбэрээр төлж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санг (ҮОМШӨДС) бүрдүүлдэг. Иргэдийн шимтгэлээс бүрдсэн энэ сангийн хөрөнгийг эргээд олон нийтийн тусын тулд зарцуулах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн мэдээллээр тус санд зөвхөн 2015 онд 109.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрчээ. Харин 2016 оны орлогын дүн бүүдгэр хэвээр байв. Тиймээс

нийтэд ил болсон 2015 оны статистикийг сөхвөл тухайн онд тус санд төвлөрсөн нийт орлогын ердөө 30 хувийг хөдөлмөр хамгаалалд зарцуулжээ. Дийлэнх буюу 70 хувийг зарцуулсан нэг үлдсэн байх юм. Ер нь 70, 30-ийн энэ харьцаа сүүлийн 4-5 жилд давтагдсан.

Өөрөөр хэлбэл, төр иргэдээс хураамж аваад, үүнийхээ 30 хувийг зарцуулаад, үлдсэнийг нь хадгалдаг гэсэн үг. Сүүлийн дөрвөн жилийн үлдэгдлийг нэгтгэвэл 245 тэрбум төгрөгийг давж байх жишээтэй. Гэтэл энэ сан байгуулагдаад 20 гаруй жилийн нүүр үзэж байгаа гэвэл тэр мөнгө лав олон тэрбум давсныг түвэггүй мэдэж болно. Хөрөнгө яг хэдэд хүрснийг албаныхнаас тодруулах гэсэн боловч тодорхой хариу хэлсэнгүй. Гэхдээ бидний хүртэх учиртай, хэмжээ нь үл мэдэгдэх тэр хөрөнгө хадгалаастай байгаа гэж найдъя.

Ийнхүү монгол хүнийг хамгаалах учиртай мөнгө өсөхийн хэрээр амиа алдсан, бэртэж гэмтсэн хүний тоо нэмэгдсээр. Ганцхан жишээ хэлье. 2012 оны есдүгээр сарын 3-ны өдөр Барилгад бетон зуурмаг шахаж байсан машин унаснаас 12 настай охин нас барсан. Энэ явдлаас хэдхэн хоногийн дараа барилгын ажил шалгаж явсан Онцгой байдлын ерөнхий газрын аврагч дээрээс төмөр унаж, нүүрсний яс нь бишарч, зүүн нүд нь хараагүй болсон эмгэнэлт явдал болов. Тэгвэл шил шилээ дарсан аймшигт ослоос нэг жилийн дараа буюу

2013 онд Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослоос урьдчилсан сэргийлэхэд нэг ч мөнгө зарцуулаагүй байдаг. Улмаар 2013 онд 51, удаах онд 56 хүн үйлдвэрлэлийн ослоор амиа алдсан байх юм. Төр өөрийн мэдлийн иргэдийн мөнгөнөөс гар татсан жилүүдэд амиа алдсан монгол хүний тоо ийн өсчээ.

Дахин нэг асуулт. Дэлхийн улс орнууд үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа алдсан хүний нөхөн сэргээх эд эрхтэн, эмчилгээнд гар татдаггүй. Хиймэл эд эрхтэнээс эхлээд эрхтэн шилжүүлэн суулгах нь осолд өртсөн иргэдэд тэтгэмжээс илүү ач тустай. Тиймээс барууны орнууд олон сая ам.доллар төлөөд ч хамаагүй эд эрхтэн суулгаж, эргээд хөдөлмөрийн армид нь

элсүүлэхийг хичээдэг байна.

Ер нь барууны орнууд үйлдвэрлэлийн ослоос урьдчилсан сэргийлэх болон нөхөн сэргээхэд мөнгө хамарладаггүй. Учир нь урьдчилсан сэргийлэх зардалд их хэмжээний хөрөнгө, хүч зарцуулбал удаах жилд нь осол, гэмтлийн тоо буурч, зарлага нь татардаг байна. Гэтэл манайд энэ зүй тогтол эсрэгээрээ. Монгол Улс нөхөн сэргээх урьдчилсан сэргийлэхийг огт урьтал болгодоггүй. 2016 онд гэхэд 2.3 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээх болон урьдчилсан сэргийлэхэд зарцуулжээ. Энэ бол ослоос улбаатай тэтгэвэр, тэтгэмжид олгож буй мөнгөнөөс хэд дахин бага дүн гэдгийг сануулья.

Санхүүгийн боломж байсаар

байхад төр түүнийг хэрхэн хөшүүн, хайнга, оновчгүй зарцуулдгийг эдгээр жишээнээс харж болно. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны бодлогыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тодорхойлдог. Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн захиран зарцуулалтыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хариуцдаг.

Албаныхан ослыг бууруулах бус амиа алдсан иргэдээ тоолсоор сууж буйн бодит жишээ энэ. Цаашлаад нийгмийн халамжид халхлагдан хөдөлмөрийн бодлого хэрхэн хөсөр хаягдаж буйн баталгаа биз. Төр хамгаалахад ийн төмөр нүүрээ харуулж байхад бид ч хамгаалалтын малгайгаа бэлдэхээс өөр яах билээ. [ЗГМ]

MIAT 2017 ОНЫ ОЛОН УЛСЫН ЗУНЫ НИСЛЭГИЙН ХУВААРЬ										
26.03.17 - 28.10.17										
Аялалын дугаар	Өдөр	Хөөрөх	Бүүх	Зогсолт	Аялалын дугаар	Өдөр	Хөөрөх	Бүүх	Зогсолт	Хүчинтэй хугацаа
Бээжин										
OM223	1.3..6.	06:10	08:25	0	OM224	1.3..6.	09:30	12:00	0	27.03.17 - 28.10.17
OM223	2.45.7.	17:55	20:10	0	OM224	2.45.7.	21:10	23:40	0	26.03.17 - 27.10.17
OM227	1.....	22:25	00:40(+1)	0	OM228	2.....	01:40	04:10	0	19.06.17 - 29.08.17
OM227	3.....	22:45	01:00(+1)	0	OM228	3.....	02:00	04:30	0	05.07.17 - 31.08.17
OM2276.	22:55	01:10(+1)	0	OM2287	02:00	04:30	0	01.07.17 - 27.08.17
Берлин										
OM135	3..6.	09:15	13:35	1	OM136	3..6.	14:55	06:35(+1)	1	29.03.17 - 28.10.17
OM1355.	09:15	13:35	1	OM1365.	14:55	06:35(+1)	1	07.07.17 - 25.08.17
Франкфурт										
OM137	4..7.	10:00	13:00	0	OM138	4..7.	14:30	05:00(+1)	0	25.06.17 - 03.09.17
OM137	2.....	10:00	13:00	0	OM138	2.....	14:30	05:00(+1)	0	11.07.17 - 30.08.17
Москва										
OM135	3..6.	09:15	10:55	0	OM136	3..6.	19:25	06:35(+1)	0	29.03.17 - 28.10.17
OM1355.	09:15	10:55	0	OM1365.	19:25	06:35(+1)	0	07.07.17 - 25.08.17
Токио										
OM501	1.3.5..	07:55	13:40	0	OM502	1.3.5..	14:40	19:10	0	27.03.17 - 27.10.17
OM5017	07:55	13:40	0	OM5027	14:40	19:10	0	04.06.17 - 24.09.17
OM5016.	07:55	13:40	0	OM5026.	14:40	19:10	0	01.07.17 - 23.09.17
OM501	2.....	07:55	13:40	0	OM502	2.....	14:40	19:10	0	04.07.17 - 29.08.17
OM5036.	13:45	19:30	0	OM5046.	20:30	01:00(+1)	0	01.07.17 - 26.08.17
Сөүл										
OM301	12.4567	08:45	12:50	0	OM302	12.4567	14:20	16:50	0	26.03.17 - 28.10.17
Бусан										
OM311	4..7.	06:05	10:35	0	OM312	4..7.	11:30	14:30	0	22.06.17 - 26.10.17
OM3117	12:00	16:30	0	OM3127	17:30	20:30	0	25.06.17 - 22.10.17
Хонконг										
OM297	2.4..7	06:25	10:55	0	OM298	2.4..7	12:05	16:45	0	26.03.17 - 26.10.17
OM2975.	06:20	10:50	0	OM2985.	12:00	16:40	0	31.03.17 - 27.10.17
OM2971	1.....	13:00	17:30	0	OM2972	1.....	18:30	23:10	0	05.06.17 - 25.09.17
Москва-Берлин										
OM135	3..6.	11:55	13:35	0	OM136	3..6.	14:55	18:20	0	29.03.17 - 28.10.17
OM1355.	11:55	13:35	0	OM1365.	14:55	18:20	0	07.07.17 - 25.08.17

(+1) - дараа өдөрт буух

*** Орон нутгийн цагаар ***

НЭЭЛТТЭЙ

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ АЖИЛД АВНА.

“Ажлын байранд тавигдах шаардлага”

- Англи хэлний багшийн мэргэжлээр төгссөн болон төгсөх гэж байгаа.
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- TOEFL & IELTS–н оноотой бол давуу тал болно.

+ Ажиллах таатай орчин

+ Үр дүнгийн нэмэлт урамшуулал

+ Өрсөлдөхүйц цалин

WWW.ABSOLUTE.MN

Холбоо барих : 7711-8288

Амьдралын хэв маяг

Бие организм санамсаргүйгээр сахар болон давсны илүүдэлд орчихдог

И.Гэрэл
ЗГМ

Хэрэв та жимс болон ногооны цуглуула, бүхэл үрийн бүтээгдэхүүн, дан хар махаар уургийн хэрэгцээгээ хангадаг бол хүнсний муруйгаас түрүүлж байж мэдэх юм. Гэхдээ жимс, ногооны “5 A Day” дэглэмийг баримталж, шим тэжээлгүй хүнснээс ангид, эрүүл жингээ хадгалах хэдий ч буруу хүнс сонгох эрсдэл үргэлж тулгарч байдаг. Тиймээс хүнсний



Хэрэв лаазалсан хүнс шиг бэлтгэчихсэн эвтэйхэн сонголт хайж байгаа бол хөлдөөсөн ногоо хамгийн зөв сонголт байх аж.

Худалдан авч болох ба болохгүй хүнс

талаарх мэдлэгээ цэгцлэх хэрэгтэй. Яагаад гэвэл хүнс бүрийг харилцан адилгүй арга замаар бэлтгэдэг. Эрүүл гэж бодсон хүнснээсээ та бодсон хэмжээнийхээ аминдэм, шим тэжээл авч чадахгүй байж мэдэх. Үнэндээ бол бие организм санамсаргүйгээр сахар болон давсны илүүдэлд орчихсон байдаг. Тиймээс хоол зүйчид, шим тэжээлийн талаар хамгийн сайн зөвлөгөө өгч чадах мэргэжилтнүүдийн мэдлэгт тулгуурлан дараах мэдээллийг бэлтгэвэл. Хүнсний ногоо, жимс, гурилан бүтээгдэхүүн, шим, уураг, сүүн бүтээгдэхүүн, өвх тос гээд өдөр тутам өргөн хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнээс зөв сонголт хийж, шим тэжээлийн дутагдлаа нөхөөрэй.

АШИГ ТУСТАЙ ХҮНСНИЙ НОГОО

Хар ногоон навчит ургамал: Бууцай, буржгар байцаа, салатны навч, далматин байцаа, цагаан

байцаа, ногоон гич, брокколи гээд хар болон гүн ногоон өнгийн навчит ургамлууд төрөл бүрийн аминдэм, эрдэс бодисоор нэн баялаг. “Үндсэндээ эд эсийг хамгаалж, дархлааны тогтолцоог тэтгэдэг эдгээр ургамал шим тэжээлийн уурхай л гэсэн үг. Илчлэг гэхээр зүйл бараг л үгүй” хэмээн Калифорнийн хоол зүйч Шэрон Пальмер хэлэв. Долоо хоногт 0.5-2 аяга навчит ургамал хэрэглэх шаардлагатай. Салаг, ороомог, хачиртай талх зэргийг нимбэг, сармистэй хольж идсэн ч болно. Гэхдээ исгэлэн амтыг таашаадаггүй бол навчит ургамлаа хүссэнээрээ боловсруулаад хэрэглэж болно.

Буурцагт ургамал: Вандуй, хар болон цоохор шош нь үр тариа, хүнсний ногоотой хамт хэрэглэж болох махгүй хоолны хамгийн гол бүрдэл юм. “Тэр чигээрээ таримал хүнс бөгөөд чихэр болон ургамлын уургаар нэн баялаг тул онцгой чанарыг нь дурдахгүй байх аргагүй. Мөн хууч өвчин эсдрэх, таргалалтад нэрвэгдэх эрсдэлийг бууруулдаг” гэж АНУ-ын хоол зүйч Палмер тайлбарлалаа. Мэдээж лаазалсан буурцагт ургамлын чанарыг лаазалсан энгийн хүнсний ногоонхтой харьцуулах аргагүй. Тэжээллэг чанартайн дээр ямар нэг давс нэмэхгүйгээр усаар зайлаад л идэж болно. Харин лаазалсан цагаан болон улаан шош элсэн чихэр, давсны агууламж өндөртэй байдаг тул эрүүл хүнсэнд тооцогддоггүй.

ТАТГАЛЗАХ ЁСТОЙ НОГООНУУД

Лаазалсан хүнс: Ийм ногоо ихэнхдээ хагас болгосон, өөр төрлийн шим тэжээлээр баяжуулж, давсаар амталсан байх нь түгээмэл. Лаазалсан ногоо сонгож байгаа бол хоолныхоо тэжээллэг чанарыг муутгах туршлага арвижиж байна гэсэн үг. Үүнээс ч дор зүйл бол лаазалсан ногоонд агуулагдах шим тэжээлийн чанарыг муутгадаг сахар, нэмэлт бодис, давс болон төрөл бүрийн амттанг мэдэхгүй хэрэглэснээр хоол хор болж хувирдаг.

Хэрэв лаазалсан хүнс шиг бэлтгэчихсэн эвтэйхэн сонголт хайж байгаа бол хөлдөөсөн ногоо хамгийн зөв сонголт байх аж. “Ийм хүнс эрүүл байдаг нууц нь ургамлын талбай дээр хөлдөөчихдөг учраас тэр юм. Тиймээс нэмэлт давсгүй, ус багатай бөгөөд хамгийн гол нь яг хэрэглэх хүртлээ хөлдүү байлгах учиртай” хэмээн хоолны мэргэжилтэн Рэйчел Брэндис хэлэв.

Цардуултай ногоо: Эрдэнэ шиш, вандуй, төмс, хулуу, чихэрлэг төмс зэрэг нь бусад ногоог бодоход амин дэм, эрдэс бодис, чихэрлэгийн агууламж их талдаа. Түүнчлэн хэрэглэсэн тохиолдолд бусад цардуул багатай хүнсгүй харьцуулахад 2-3 дахин их илчлэг авна гэсэн үг. Харвардын их сургуулиас сүүлд хийсэн нэгэн судалгаа төмс, эрдэнэ шиш, вандуй идсэнээс

навчит болон тонолжин ногоонууд нь жин хаяхад илүү үр дүнтэйг харуулжээ. Тиймээс нүүрсус ихтэй, цардуултай ногоог үдээс өмнө идсэн нь дээр гэдгийг доктор Рожер Адамс зөвлөлөө.

ХАМГИЙН САЙН ЖИМС

Авакадо: Тосны агууламж өндөртэй ч айлтгүй. Моноханаагүй тосны хүчил тул зүрхэнд эрүүл гэсэн үг. Энэ чанараараа авакадо нь эрүүл тосны хамгийн сайн эх үүсвэр болдог ба 10 гаруй төрлийн хамгийн чухал шим тэжээл агуулдаг. Сахар болон Е, В аминдэм, калигаар баялаг. Нэг авакадогийн дөрөвний нэгийг үдээс өмнө нэг салаттай идсэн байхад бүтэн өдрийн эрч хүчээ сэлбэнхдэг. Худалдаж авахаар бол бага зэрэг зөөлөрсөн нь дээр гэдгийг санахад илүүдэхгүй.

Зэрлэг жимс: Нэрс, хад, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, улаалзганад байдаг гүн өнгийн пигмент нь анти-оксидант чанартай ба антоциан болон полифенолын нэгдлээр баялаг. Мөн А аминдэмээр бялхсан, бага илчлэгтэй. Ялангуяа нэрс нь анти-оксидант агууламж ихтэй тул зүрх болон сэтгэцийн олдмол өвчнөөс сэргийлдэг. Өдөрт нэг аяныг тогтмол хэрэглэснээр С аминдэм, шаардлагатай эрчмийг тэтгэх макро тэжээлийн элемент болох манган зэрэг эрдсийн хангалттай эх үүсвэр болно. Тиймээс долоо хоногт ядаж гурван аяга зэрлэг жимс хэрэглэх хэрэгтэй.

Хөлдөөсөн жимс: Хөлдөөсөн ногооны адилаар жимсийг ч мөн ургамлын талбайд хөлдөөдөг. Тэр хэрээр баялаг шим тэжээлээ алдаагүй байдаг. Ийм жимсний сонголт дээр “жимс” гэсэн ганц л үг бий. Хөлдөөсөн жимсийг гэгсгээгд төрөл бүрээр хэрэглэж болно.

ЖИМСНИЙ ХАМГИЙН МУУ СОНГОЛТ

Савласан шүүс: “Жинхэнэ жимс” гэсэн шошготой шүүсүүд ч эрүүл мэндэд ялгаагүй муу. Их хэмжээний сахар, эсвэл сахар орлуулагч хийсэн байх агаад илчлэггүй. Сахарын агууламжийг нь багасгахын тулд сахар оруулагч хэрэглэдэг ч үнэндээ чихэрлэг, давслаг, эрүүл мэндэд муу тосны агууламж бүхий хүнс хэрэглэх дур хүслийг нэмэгдүүлдэг. Зөвхөн савласан шүүснээс татгалзаад хангалтгүй юм. Цэвэр шүүсний ч сахарын агууламжийг нэмэгдүүлсэн байдаг аж.

Хатаасан болон лаазалсан жимс: Уг нь жимсэнд байгалийн сахар агуулагддаг. Тийм болохоор нэмэлт сахар болон лаазалсан жимсэнд ихэвчлэн хэрэглэдэг чихэрлэг амт оруулагчийг хэрэглэх шаардлагагүй юм. Сахарын нэмэлт нь шаардлагагүй илчлэгийг л нэмэгдүүлдэг. Хатаасан жимс ч мөн нэмэлт сахартай. Үзэм гэхэд л үндсэндээ хатаасан усан үзэм. Тиймээс нэг

аяга үзэмд агуулагдах илчлэгийн хэмжээ нэг аяга усан үзэмнийхээс хавьгүй их.

ҮР ТАРИАНЫ АЛЬ НЬ САЙН БЭ

Бүхэл үрийн гурил: Хүмүүс жингээ бууруулж, эрүүл мэндээ тэтгэхийн тулд гурилаа багасгах хэрэгтэй гэж үздэг. Харин үнэн чанартаа целиак буюу цавуулагт мэдрэг өвчтэй л биш бол өдөр бүр үр тариа хэрэглэж байх учиртай. Энэ төрлийн хүнс нь тэжээллэг, ургамлын уураг болон амин дэм, эрдэс бодисоор баялаг юм.

Овьёосны нэвс: Овьёосны найрлагад омега-3 тосны хүчил, фолийн хүчил, кали их тул зүрхний үйл ажиллагаанд сайн, холестериний хэмжээг бууруулж, тос шатаадаг байна. Гэхдээ савласан овьёос сахарын нэмэгдэлтэй. Үүний оронд энгийн овьёосны нэвсийг зөгийн бал, жимсээр амтлаад идвэл өглөөд цагаа хэмнэнэ.

Цагаан талх, паста гоймонгоос татгалзаарай. Паста болон будаа, кракер, цагаан талх зэрэг цэвэршүүлсэн үр тарианд агуулагдах сахар нь цусанд маш түргэн шимэгддэг. Ингэснээр цусан дахь сахарын хэмжээ ихсэх нэг шалтгаан болдог. Бүхэл, эсвэл сайжруулсан үр тариагаар хийсэн бүтээгдэхүүн гэдгийг мэдэхийн тулд шошгыг харахад л хангалттай. “Бүхэл” гэж үг хамгийн түрүүнд байвал бүхэл

үрийн, харин зүгээр “буудай” гэсэн байвал сайжруулсан буюу цавуулаг ихтэй гэж ойлгох хэрэгтэй.

УУРГИЙН ХЭРЭГЛЭЭНД СОНГОЛТ ЧУХАЛ

Загас: Далайн гаралтай хүнс нь магадгүй таны идэж буй хамгийн эрүүл уураг байх. Судасны болон төрөл бүрийн үрэвслийг бууруулдаг омега-3 тосны хүчлээр дэндүү баялаг тул цусны даралтыг зохицуулж, гэдэс цочролын хам шинж, астма, зарим төрлийн хорт хавдар тусах эрсдэлийг бууруулдаг. Түүнчлэн өдөр тутмын хэрэглээ болгосноор депресс, түгших зовиур багасдаг аж.

Тахиа: Хальсийг нь авсан тахианы мах жирийн улаан махтай харьцуулахад ханасан тосны агууламж багатай. Тиймээс идсэн хүнсийг биед эрчим хүч болгон хувиргадаг никотины хүчлийн гол эх үүсвэр болдог. Мөн дархлааны тогтолцоо, танин мэдэхүйг өдөөдөг селенээр баялаг.

Дуфу: Цагаан хоолтон, веган хүмүүст уургийн гол эх үүсвэр болдог. Зохистой хэрэглэвэл зүрхний өвчлөл, хорт хавдраас сэргийлэх зэрэг олон талын ашиг тустай.

Самар: Зүрхний үйл ажиллагааг дэмжих тос, олон төрлийн аминдэм, уураг, эрдэс бодисыг ганц үмхээд л аваарай. Гэхдээ савласан, эсвэл тосонд хуурсан самар бол нэмэргүй. Оронд нь өөрөөр нь хуурч, давс нэмээгүйг сонгосон нь дээр.

Өндөг: Зөвхөн цагаан уураг нь ч биш бүхлээрээ сайн. Өндөгний шар нь Е аминдэм болон тархины үйл ажиллагаа, бодисын солилцоонд гол үүрэг гүйцэтгэдэг холиноор баялаг.

Улаан буюу үхэр, хонь, гахайн махыг эсэргүүцэх бодол санаа,

үйл ажиллагаа өргөжиж байна. Яагаад гэвэл холестерин, ханасан тос ихтэйн дээр хэт их хэрэглэх нь зүрхний болон чихрийн шижингийн ужиг өвчинтэй болох эрсдэлтэй аж.

Хагас боловсруулсан мах: Эрүүл хүнсний сонголт гэдэг дүрэм уурагт ч гэсэн үйлчилдэг. Хиам, зайдас болон зүсэж бэлтгэсэн мах нь их хэмжээний давс, ханасан тос, хадгалалтыг удаашруулах нэмэгдэл агуулагдсанаар хоол зүйн мэргэжилтэн Адамс анхааруулав. Хэдийгээр хааяа идэхэд зүгээр ч тогтмол хэрэглэвэл зүрхний өвчин, шулуун гэдэсний хавдартай болох аюултай аж.

САЙН СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Грек йогурт: Жирийн йогуртаас хоёр дахин их уураг агуулдаг энэ амттан удаан хугацаанд цагталан мэдэрэмж түрүүлж, сайн чанарын кальцийн гол эх үүсвэр юм. Тослог багатай энэ йогуртыг майонез, цөцгийнний оронд төрөл бүрийн хүнсэнд хэрэглэж болно.

Коттеж буюу гэрийн бялаг: Уургаар баялаг, нүүрсуны агууламж тун бага тул өдөрт авах нүүрсуны хэмжээндээ хязгаар тавьсан нэгэнд гайхалтай сонголт. Мөн тал бүрийн ашигтай хүнс. Блэндэрт хийгээд сүүт эсвэл өглөөний цайнд хэрэглэх уургаар хүнс болгож болно. Давсны нэмэлт багатай, тал аяга котже бүтэн өдөрт хангалттай гэдгийг Палинскний Уйд зөвлөжээ.

Амталсан йогурт: Ийм төрлийн йогурт 30 грамм хүртэл элсэн чихэр агуулдаг. 30 гр гэдэг 6.5 халбага сахар гэсэн үг. Өглөөний цайндаа нэг ширхэг амталсан йогурт идлээ гэхэд өдрийн хоолны цаг ч хүртлгүй өлсөж эхэлдэг. Үнэхээр идмээр байвал чихрийн нэмэгдэл нь 10 гр-аас ихгүй, уургийн агууламж нь зургаан гр-аас багагүйг худалдаж авахыг Брэндис зөвлөлөө.

Шахмал сыр: Их хэмжээний давс агуулдаг. Ийм нэг зүсэм сырийн хавчуургаатай зүсэм талх 700 мл хүртэлх буюу насанд хүрсэн хүний тал өдрийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний давс агуулдаг.

ТОС

Оливын тос: Extra буюу сайн чанарын оливын тос нь зүрхний өвчин, цус харвалт, чихрийн шижингийн хоёрдугаар үе болон ясны сийрэгжилтээс сэргийлдэг. Оливын тосыг өргөн дэлгэр хэрэглэдэг Газрын дундад тэнгис орчмын хоолны дэглэм баримтлагчид үр удаан, эрүүл амьдардаг нь олон судалгаагаар батлагдсан байна.

Транс тос: Ихэвчлэн шарсан хүнс, нарийн боов, боловсруулсан хөнгөн зуушинд устөрөгчөөр баяжуулсан гэх транс тос их агуулагддаг. Үнэ хямд, хэрэглэхэд зовлон багатай, удаан хадгалж болдог тул хүнс үйлдвэрлэгчид энэ тосонд их “хайртай”. Харамсалтай нь бие дэх муу холестеринийг ихэсгэж, сайныг нь багасгаж байдаг транс тосыг идэх тусам цус харвах, зүрхээр “одох” магадлал нэмэгддэг. Транс тосноос татгалзах нэг боломж бол удаан хадгалж болдоггүй хүнс сонгох явдал. АНУ-ын Хүнс, эмийн захиргаанаас уг тосны хэрэглээг 2018 он гэхэд хүнс үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний агууламжаасаа бүрэн халсан байх шийдвэр гаргажээ. [ЗГМ]

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]
СОНИН ХИХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртотх
Утас: 99901532

Гадаад контент, соёл, интерактивментын алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Go
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Л.Сугармаа



8965800040291124 00603



ЯГ ОДОО УТСАНДАА СУУЛГААРАЙ

Available on the App Store | Get it on Google Play

ubinfo.mn



МОНГОЛД ХАМГИЙН ИХ АШИГЛАГДАГ ГАР УТАСНЫ АПП UB INFO

ТА ХОЦРООГУЙ БИЗ?

ЗГМ: Сэдэв

Цэцэрлэгт хүрээлэн бус жижиг худалдааны хар зах

Өнгөрсөн жил цэцэрлэгт хүрээлэнд гурав орчим тэрбум төгрөг төсөвлөжээ

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM



Б.Ганбаяр / ЗГМ©

Хатуу хахир өвлийн өдрүүд алслан холдож урин дулаан хаврын өдрүүд айсуу. Хотын иргэд гэр хорооллын саарал утаанаас салж, модод гөлөглөж, байгаль дэлхий өнгө нэмэн сэтгэл тэнийх цаг хэдийнэ болжээ. Урин дулаан цаг ирэхээр нийслэлийнхний очих дуртай газар бол Үндэсний цэцэрлэгт хүрээлэн. Эл газар нийслэлчүүд төдийгүй гаднын жуулчид, хөдөө орон нутгаас ирэгсэд олноор цугладаг.

Манай сонины сурвалжлах баг өчигдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг зорилоо. Хаврын зөөлөн салхи сэвэлзэж, хаа нэг өлгийтэй хүүхэд тэвэрсэн аав, ээжээс өөр холхих хүнгүй эл хульхан байв. Цэцэрлэгт хүрээлэнгийн машины зогсоол урьд нь хариуцах хүнтэй, төлбөртэй байсан бол энэ удаа асууж сураглах, төлбөр мөнгө авах хүнгүй байлаа. Хүрээлэнгийн үүдээр ороход бүх зүйл нэг л дүнсгэр байгаа нь уйтгартай аж. Ганц нэг хүрнсий бүтээгдэхүүн худалдах буфет онгорхой харагдана билээ. Арга ч үгүй биз. Тавдугаар сар гарч, мод, цэцэгс өнгө алаглаж, нарны илч наашлах харахан болоогүй байна. Шинээр тавьж байгаа дугуйн зам, ногоон байгууламж, амарч суух газар барьж, байгуулж буй нэгээхэн ч зүйл нүдэнд торсонгүй. Шинэ даргатай болж халаа сэлгээнд өртсөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ийн дүнсийнэ.

Уг нь хүүхэд, хөгшдийг угтах бэлтгэлдээ орж, өнгө зүсээ сайжруулж байх ёстой газар хөсрийн царайгаа засах янз алга. Байгалийн жам хойно зүлэг нь ногоорч, тарьсан модод нь цэцэглэх байх. Гэхдээ л сандал, бас бус зүйлээ будаж тордож өнгийг нь сэргээхээс эхлээд ажил баймаарсан.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг

2009 онд байгуулснаас хойш өдгөө долоон жилийг үджээ. Энэ хугацаанд хэдэн хөшөө, баримал босгож, дугуйн замыг өргөтгөснөөс өөр хийсэн зүйлгүй хэвээр. Өнгөрсөн жил гэхэд усан оргилуур, цэвэрлэгээ үйлчилгээ, зам талбайн ажилд нийт гурван тэрбум орчим төгрөг төсөвлөсөн байна. Гэтэл “Чонын элч” хөшөө, чийрэгжүүлэх талбай буюу цөөн хэдэн төмөр төхөөрөмж, Сөүл хотын нэрэмжит ой гэгдэх бетонон хашаатай, сүүдрэвчтэй элстэй талбайг л байгуулжээ.

Монголын цэлмэг тэнгэрийг харахаар ирсэн жуулчдын саатах газрын нэг

Төсөвлөсөн энэ их хөрөнгө мөнгөөр энэ байтугай зүйл хийж, цэцэрлэгт хүрээлэнд өнгө нэмж болохоор. Ингээд бид энэ жил Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ямар байдлаар ажиллах, эмх замбараагүй жижиглэн худалдааг хэрхэн зохицуулах талаар тодруулахаар шинэ дарга С.Эрдэнэтуултай холбогдож уулзах цаг товловсон боловч тэрбээр ирсэнгүй.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн

бол сая гаруй хүн амтай Улаанбаатар хотын хамгийн том ногоон байгууламж бүхий цогцолбор. Тус газрыг зорих хүмүүсийн тоо нийслэлийн иргэдээр хязгаарлагдахгүй.

Жилийн 250 өдөрт нартай байдаг Монголын цэлмэг тэнгэрийг харах гэж ирсэн жуулчдын саатах газрын нэг. Аяллын хөтөч, тайлбарлагчдын жуулчдад үзүүлэх тоотой хэдэн газрын нэр дээр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн багтсан байна билээ.

Манай оронд өнгөрсөн жил 440 мянга орчим жуулчин ирсэн гэх статистик мэдээ бий. Гаднынхан манай цэцэрлэгт хүрээлэнг хараад халагладаг ч байж магадгүй. Учир нь иргэдийн тав тухыг дээд зэргээр хангасан төгс тохижилттой газар биш болохоор тэр. Ядаж ойр хавьд нь явган хүний гарц алга. Зүүн гар талаас машины урсгал орж ирж байгаа учраас нэлээд анхаарал, болгоомжтой байхгүй бол хүүхэд байтугай том хүн ч осолд өртөж, гэмтэх эрсдэлтэй байна. Дээр нь нам гүм орчин, тайван байх ёстой газар зуны цагт яг л “Нарантуул” зах руу орсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. Зохион байгуулалтгүй, эмх амбараагүй худалдаа, үйлчилгээнд хүмүүс бухимддаг болсон. Хүсэлт, гомдол гаргасан ч хүлээж авч буй нь ховор байдаг аж. Энэ мэтчилэн нийслэлийн иргэдийн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин

үеийн тохилог орчныг бий болгохоор зорьж буй Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн зорилт, зохион байгуулалт нь алд дэлэм зөрсөөр ирлээ. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудын цэцэрлэгт хүрээлэн манайхаас хавь илүү сайхан. Зүлгэн дээр суугаад амарч тухлах эрх чөлөө тэнд л бий. Харин манай цэцэрлэгт хүрээлэн иргэдийг зүлгэн дээр сууж болохгүй гэсэн шаардлага тавьдаг. Энэ мэтээс эхлээд боловсорч бойжих болоогүй байна.

НОГООН БАЙГУУЛАМЖААР ГАЙХУУЛАХ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

Канад улсын Монерал хотын “Jardin Botanique” цэцэрлэгт хүрээлэн 75 гектар талбайтай, 22 мянга орчим төрөл зүйлийн мод, бут сөөгтэй бөгөөд 695 мянга орчим нэг наст ургамал ургадаг байна. Тус хүрээлэнгийн ургамлыг 31 хэсэг болгон төрөлжүүлсэн бөгөөд жилийн аль ч улиралд үзэж сонирхох боломжтой хүлэмжийг байгуулжээ. Үүгээр ч зогсохгүй тус газар явган хүн, дугуйны нарийн замаас өөр цементэн замгүй ногоон байгууламж зонхилсон байдаг. Иргэдээ амрахад зориулсан хиймэл нуураас гадна тухалж цайлах зүлгийг гарьж ургуулжээ. Жилийн дөрвөн улиралд амарч, зугаалах ая тухтай орчныг бүрдүүлж чадсан байна. Манайх ч

гэсэн ганцхан зуны улиралд өнгө нэмдэг хүрээлэн биш жинхэнэ утгаараа цэцэрлэгт хүрээлэн болох хэрэгтэй байна.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж тийм ч том талбайг эзэлдэггүй. Харин эсрэгээрээ дугуй, гүйлт, явган хүний гээд цементэн зам ихэнх талбайг нь эзэлнэ. Үүгээр ч зогсохгүй төмөр баримал, хөшөө ч цөөнгүй бий.

Амралтын өдрүүдэд ая тухтай өнгөрөөх гэж зорьж очсон хүмүүсийг шорлог хийх нэрээр гашуун утаагаар утаж, энд тэндгүй “Хоёр мянгаар 12 сум шидээд хүссэн тоглоомоо аваарай”, “Хүүхдээ суулгаад үзээч нэг тойроход 3000 шүү”, “Хөөсөн чихэр аваарай”, “Халуун зайдас байна” гэх дуу хадаж, хажуугаар өнгөрсөн нэгнийг барьж авах нь холгүй авирлах худалдаачид, төв хаалганаас эхлэн намхан тавиур дээр хүүхдийн анхаарлыг татахаар өрсөн нүд эрээлжлэм, өнгө өнгийн тоглоомууд худалдаж хар зах дээр яваа мэт санагдуулдаг нь түвэгтэй. Шөнө оройн цагаар эл худалдаа илүү нэмэгддэг. Гэтэл Унгар, Австри, Швейцарь зэрэг улсын цэцэрлэгт хүрээлэнд хүмүүс амарч, зугаалах, гэр бүлээрээ чөлөөт цагаа тайван өнгөрүүлэх гэж ирдэг. Харин Монголын цэцэрлэгт хүрээлэнд алжаал тайлахаар очсон хүмүүс ядарч сульдаад буцдаг гэхэд хийлсэхгүй. [ЗГМ]

Дэлхийн үнэт цэцэрлэгт хүрээлэн

ФРАНЦЫН “VILLA EPHRUSSA DE ROTHSCHILD”



Энэхүү цэцэрлэгт хүрээлэнд чидун жимсний мод, уруул цэцэг (лаванда) болон бусад цэцэгсийг битүү тарьсан байдаг аж. Олон тооны баримлуудын хажууд өнгө нэмэн чимэх ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэнгийн харшийг илүү том болгож харагдуулдаг байна. Мөн зөвхөн Испани, Японд ургадаг цэцэгсийг тарьсан нь зочдод ер бусын гайхалтай мэдрэмж төрүүлдэг гэнэ. Мөн тус газар нь 2011 онд дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй цэцэрлэгт хүрээлэнгээр тодорч байжээ.

СИНГАПУРЫН “BOTANIC GARDEN”



Дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй цэцэрлэгт хүрээлэн бөгөөд 1859 онд анх байгуулагджээ. Тус газрын ногоон байгууламж нийт 128 га талбайг эзэлдэг аж. Цэцэрлэгийн төв хэсэгт 60 мянган цахирмаа цэцгийн үндэсний хүрээлэн байрладаг байна.

АРАБЫН “MIRACLE”



Дубай хотод дөрвөн километрийн явган хүний өргөн замтай, 7200 метр квадрат талбайг хамарсан 45 сая амьд цэцэгээр дүүрсэн ногоон төгөл бүхий цэцэрлэгт хүрээлэн байна. Тус цэцэрлэгт хүрээлэнг 2013 онд байгуулжээ.

ИТАЛИ “VILLA D'ESTE”



Хамгийн гоёмсог чимэглэгдсэн энэхүү хүрээлэн дэлхий нийтийн сонирхлыг ихэд тагдаг аж. Тус хүрээлэн хэдэн зуун усан оргилуураар хүрээлэгдсэн бөгөөд тэдгээр нь амьтны толгойн баримал, цэцэгс, жижиг завьнуудаас оргилон гардаг өвөрмөц шийдэлтэй. Энэхүү цэцэрлэгт хүрээлэн 2008 онд байгуулагдсан байна.

КАЛИФОРНИ МУЖИЙН “DESCANSO CARDENS”



Америкийн Лос-Анжелес хотоос 20 минутын зайд орших энэхүү цэцэрлэгт хүрээлэнд 100 мянга гаруй ургамал ургадаг ажээ. Хүрээлэнгийн цэцэгсийн ихэнх хэсгийг Камелия цэцгийн мандал эзэлдэг бөгөөд дэлхийн хамгийн том цуглуулгаар тодорчээ. [ЗГМ]

Шилдгүүдийг нэг дороос...

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА.
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 30,000₮



УЛИРАЛД

64 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

Спорт

Супер оддын дампуурал



60 саяыг юу ч үгүй үрчихсэндээ харамсаж явдгаа өгүүлжээ

Б.Тэмүүлэн
ЗГМ

Мэргэжлийн спортын тамирчид залуудаа их хэмжээний мөнгө олдог ч үүний хэрээр үрж дуусгах нь олонтой. Хэдэн арван сая ч биш, замналынхаа турш зуу, зуун саяыг олдог ч ухаангүй бодлого, үрэлсэн зангаасаа болж дамбуурсан тамирчдын талаар өгүүлэв.

АЛЛЕН АЙВЕРСОН

Аллен 14 жилийн карьерийнхаа турш зөвхөн цалингаас 154 сая ам.долларыг олсон байдаг. Оргил үедээ тэрбээр “Reebok” компанитай таван жилийн 50 саяын гэрээ байгуулаад зогсохгүй дараа нь үүнийгээ шинэчилж, бүх насаараа тус

компанийг сурталчилсан анхны тоглогч болсон. Харамсалтай нь түүнийг гай дайрч, Денвер болон Атланта дахь хоёр ч эдлэнгээ банкинд хураалгаж, эхнэрээсээ салж, мөрийтэй тоглоомонд ихэнх мөнгөө алдсан гэдэг. Өдгөө Аллен дансан дахь 30 сая ам.долларт 2030 он хүртэл гар хүрэх эрхгүй болчихоод байна.

ЖАМАРКУС РУССЕЛЬ

NFL-ийн ирээдүйтэй залуу холбогчдын тоонд багтаж явсан ЖаМаркус Руссель 2007 онд драфтаар “Окленд Рэйдерс” багт очсон. “Рэйдерс” залуу од тоглогчтой дөрвөн жилийн 61 сая ам.долларын гэрээнд гарын үсэг зурсан юм. Гэвч Руссель хар тамхины улмаас мэргэжлийн замналаа удаан үргэлжлүүлж чадаагүй. Тэрбээр шоронд суух нь тодорхой болж, эдлэнгийнхээ мөнгийг ч төлж чадахгүй болтлоо уруудсан юм.

ЭВАНДЕР ХОЛИФИЛЬД

Боксын ертөнцөөс дамбуурсан ганц хүн нь Тайсон биш. Мэргэжлийн боксын аваргын бүсийг дөрвөн удаа эзэмшиж явсан

Эвандер Холифильд ч бас ийм асуудалд орсон. Энэ нь ердөө хоёрхон шалтгаантай. Эхнийх нь маш их алдагдалтай бизнес түүнийг ийм зам руу түлхсэн бол сүүлийнх нь олон хүүхдийн мөнгө төлдөгтэй холбоотой. Тэрбээр зургаан өөр эмэгтэйд нийт 11 хүүхэдтэй. 2008 онд Атланта дахь 109 өрөөтэй эдлэнгээ зээлийн улмаас алдсан гэнэ.

МАЙК ТАЙСОН

Мэргэжлийн боксын домогт аварга Майк 400 сая “ногоон” олсон ч хар тамхи, гэмт хэргийн улмаас дамбуурсан оддын тоонд орж буй. Аргаа барсан ахмад боксчин шоу нэвтрүүлэгт ороцож, кинонд тоглох зэргээр амь зогоож байна.

ЖОН ДЭЛИ

Баячуудын спорт гэгддэг гольф Жон Дэли нэгэн үе гялалзаж байлаа. Гэвч тун хурдан мөнгөгүй, ядуу нэгэн болж хувирсан. 2004 онд архины өмчилгээ хийлгэсэн тэрбээр 60 сая ам.долларыг юу ч үгүй үрчихсэндээ харамсаж явдгаа дурсамж номдоо бичсэн байдаг.

ЛЕННИ ДЮКСТРА

MLB-ийн “Нью-Йорк Метс”, “Филадельфи Филлес” багуудад тоглож, гурван удаа Бүх оддын тоглолтод оролцсон Ленни 1997 онд зодог тайлсан. Их спортоо орхисноос хойш бизнесийн ертөнцөд хөл тавьж, машин угаалгын газар ажиллуулж эхэлсэн боловч 2007 онд түүнийгээ зарсан юм. Энэ хооронд сэтгүүл гаргаж үзсэн ч бас л бүтэлгүйтэв. Өр зээлэнд ороогдсон тэрбээр бүх мөнгөө банкинд алдсан гашуун түүхтэй.

МАЙКЛ ВИК

NFL-ийн “Филадельфи Иглс”-ийн холбогч Вик нохой зодолдуулсан хэргээр 18 сар “аавын хаалга” татсан. Үүнээс үүдэн олон сая долларын гэрээгээ алдаж, хамтарч ажилладаг байсан бизнесийн байгуулагууд нь нүүрээ буруулснаар бүр мөсөн дамбуурав.

ЭНТУАН УОЛКЕР

NBA-д 12 жил тоглохдоо 110 саяас илүүг олсон Уолкер зодог тайлаад хэдхэн жилийн дараа хөгжлийн лигт тоглох болсон нь сасган бөмбөгөө санасных биш байв. Мөрийтэй тоглоомонд байдгаа тавиад туучихсан түүнд мөнгөний хэрэг гарсан учраас эргэн ирсэн хэрэг.

Тэр зөвхөн цалингаараа амьдраагүй. Ид үедээ “Adidas” брэндтэй гэрээ байгуулж, 1999 онд “NBA Live 99” видео тоглоомын эхний нүүрэнд заларч, 60-65 орчим сая “ногоон” олсон гэдэг.

ЛЭТРЕЛЛ СПРЮЭЛЛ

NBA-ийн сахилгагүй тоглогчдын нэг Лэтрелл 2005 онд “Миннесота Тимбервулвз” багийнхаа тавьсан гурван жилийн 21 сая долларын гэрээнээс татгалзсан шалтгаанаа “Ийм өчүүхэн мөнгө үр хүүхдээ тэжээхэд хангалттай хурэлцэхгүй” хэмээн тайлбарласан аж. Эдлэн газрынхаа сарын төлбөрийг төлж чадахгүйд хүрсэн Лэтрелл 2005 оноос хойш лигт тоглоггүй юм.

СКОТТИ ПИППЕН

Нэгэн цагт “Чикаго Буллз”-ийн од асан Скотти Пиппен карьерийнхаа турш 120 сая ам.долларыг зөвхөн цалингаасаа олсон гэдэг. Харамсалтай нь домогт тоглогч дамбуурлаа зарлаж, энэ бүхнээс гарахын тулд өөрийн эд хөрөнгөө зарсан байна. [ЗГМ]

ОЛИМПИЗМ



Хоккейчид олимпийг хүсэж байна

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

NHL-ийн Тоглогчдын холбооны тэргүүн Доналд Фер Пёнчаны өвлийн олимпод хоккейчид оролцохыг маш их хүсэж байгаа хэмээн ярьжээ. Тиймээс NHL шийдвэр гаргахдаа үүнийг бодолцож, тамирчдынхаа эрх ашгийг нэн түрүүнд тавих ёстойг сануулсан байна.

Өвлийн олимпийн наадам нэг, хоёрдугаар сард болдог тул хоккейн хамгийн хүчирхэг лиг болох NHL-ийн улирлын тоглолттой давхцдаг. Энэ үеэр NHL бүтэн сарын турш улирлаа завсарлуулж, үүнээс болж асар их алдагдал хүлээхэд байдалтай юм. Тиймээс NHL-ийн комиссар Г.Беттмэн Пёнчаны олимпод тамирчдаа оролцуулах бодолгүй байгаагаа илэрхийлсэн билээ.

Хэрэв NHL-ийн одод ирэхгүй бол олимпийн хоккейн тэмцээн бусдын сонирхлыг татахаа болино. Монголын нөхцөл байдалтай зүйрлүүлбэл, улсын баяр наадамд том цолтой бөхчүүд зодоглохыг хориглож, дандаа аймаг, сумын цолтнууд хоорондоо барилдахаас өөрцгүй болох юм. Тиймээс хоккейн хорхойтнууд асуудал нааштай шийдэгдээсэй хэмээн хүлээж сууна.

“NHL бол ямар ч зүйлд дандаа хариу нэхэж байдаг байгууллага. Тэдний хувьд хэн, хэдий хэрийн төлбөр төлөх вэ гэдэг л сонин. Гэтэл тамирчдын хувьд олимпийн наадам гэдэг онцгой зүйл. Тэд олимпод ам-

жилттай тоглож, эх орондоо туслахыг нэр төрийн хэрэг гэж үздэг. Хэрэв NHL тамирчдаа оролцуулахаас татгалзвал энэ нь цаашид тамирчид болоод лигийн хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Нөхцөл байдал хэрхэх талаар урьдчилсан таамаг дэвшүүлэхэд эрт байна. Одоо хүлээх л үлдлээ. Гэхдээ хувийн бодлоо хэлэхэд, хэрэв хориг тавибал хоккейчид таагүй хүлээж авах байх” хэмээн Доналд Фер ярьжээ.

Олимпийн наадам болж лиг алдагдал хүлээдэг тул Олон улсын олимпийн хороо болоод Олон улсын хоккейн холбоо тус байгууллагад нөхөн төлбөр төлдөг. Өнгөрсөн Сочигийн олимпиаар л гэхэд ОУОХ 14, ОУХХ 18 сая ам.долларыг нөхөн төлбөрт өгч байв. Харин энэ удаа эдийн засгийн хүндрэлээс болоод төлбөр өгч чадахгүй гэдгээ илэрхийлсэн нь NHL-ийн дургүйг хүргэж орхисон юм. Тиймээс тамирчдаа олимпод илгээхгүй гэсэн байр суурь илэрхийлсээр байна.

Өмнө нь олимпийн наадамд мэргэжлийн хоккейчид оролцдоггүй байв. Харин ОУОХ, ОУХХ болон NHL зөвшилцөлд хүрсний эцэст 1998 оноос дэлхийн шилдэг хоккейчид олимпод хүч сорих болсон. Ингэснээр хоккейн тэмцээн олимпийн хамгийн үзүүштэй төрөл болж хувирсан билээ. Харин энэ удаа талууд зөвшилцөлд хүрэхгүй бол Пёнчаны олимпийн хоккейн тэмцээн давсгүй хоол мэт болох нь. [ЗГМ]

UBshop.mn
ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

- 1 SONATA-6 маш хямд зарна 2-3 хоногийн өмнө орж ирсэн.
Утас: 96481125
- 2 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна.
Утас: 96481125, 99087992
- 3 Mercedes Benz E-200 дизель авто машин зарна. 2004 оны 2011 онд орж ирсэн дизель 2000cc автомат. Хот дотор 10 иднэ. Германаас орж ирсэн. Тогтмол дулаан гражид байдаг. Хар өнгөтэй E 200.
Утас: 99289768
- 4 225/60/R16 Kumho Solus дугуй зарна.
Утас: 99135791
- 5 Nissan Teana зарна.
Утас: 99796159
- 6 2001 оны 2012 орж ирсэн. ямар ч асуудалгүй Prius 11 зарна.
Утас: 99829768
- 7 Ачааны зориулалттай автомашин маш хямд зарна
Утас: 96481125, 99087992
- 8 Автомашины хагарч цуурсан шил наагч зарна. Хүргэлтэй. Үнэ: 35000 төгрөг
Утас: 99679962
- 9 Шинэ дугуйнууд зарна. Үнэ: 100.000 төгрөг
Утас: 88006734

КОМПЬЮТЕР БА
ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

- 1 Skynet-ийн modem зарна.
Утас: 80286525, 86203222
- 2 3 дугаар үеийн i5 процессор, 2 GB ram, 583 GB хард диск, 15.6" дэлгэц бүхий Toshiba Satellite C850 модель нөүтбүүкнийг утасгүй маус, цүнхний хамт зарна.
Утас: 95530099
- 3 Оригинал Wifi хүлээн авагч хямд зарна. 150 метр хүлээн авна.
Утас: 91228822, 95228822
- 4 Notebook үнэ тохирч худалдаж авна. Ломбарднаас чөлөөлж авна.
Утас: 91228822 95228822
- 5 900x400x2mm рад хямд зарна.
Утас: 91228822, 95228822
- 6 Пролонон хамгаалалттай, 5.5 см диаметрэй. Хүмүүсийн сонирхлыг татахуйц дизайнтай, гар утас, компьютер, нөүтбүүк, бусад төхөөрөмжинд залгаж болно. LED гэрэлтэй, дотроо батарейтай. 3.5mm аудио, USB цэнэглэгч кабель дагалдана. Өнгөний сонголттой.
Утас: 96012938, 88512938
- 7 Гэр болон оффиссын сүлжээ хүрдэггүй газарт сүлжээ дахин дамжуулагч суурилуулна. Угсралт тохиргоо үнэгүй.
Утас: 75752020

ҮЛ ХӨДЛӨХ

- 1 40 тонн контейнер маш хямд зарна.
Утас: 90666913 96481125
- 2 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна.
Утас: 99289768
- 3 Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна.
Утас: 99289768
- 4 2 өрөө үйлчилгээ явуулах боломжтой байр зарна БЗД 8-р хороо Баянзүрх хотхон 108-р байрны 1-р давхарт дэлгүүр, сургалт, цэцэрлэг, үйлчилгээ явуулах боломжтой 43 мкв 2 өрөө байр хямд зарна. Хаяг: Офицерийн тойргоос уруудаад Баянзүрх хотхон 108-р байр
Утас: 80612065
- 5 Апартамент-88 орон сууц ХЯМД зарна УТАС: 99289768 Сансарын тунелд 1 давхарын 3 өрөө байр зарна.
Утас: 99760217, 99101271
- 6 Хотын төвд бүрэн тавилгатай пентхаус гал тогоо тусдаа 5 өрөө байр хөлслүүднэ.
Утас: 99760217, 99101271
- 7 Сансар Цагдаа хотхоны зүүн талд 2016он ашиглалтанд орсон 2 өрөө 41,1 мк2 байр хямд зарна.
Утас: 91228822, 95228822
- 8 Засвар хийсэн 1 өрөө байр түрээслүүлнэ.наран талдаа цонхтой.
Утас: 99188626, 86269918
- 9 Төв аймагт 6 айлын зуслангийн газар зарна.
Утас: 95347403
- 10 Төмөр замд СОТ-н таван давхарт угсармал байрны хоёр өрөө байр зарна.
Утас: 99466494

НОМ, ХЭВЛЭЛ

- 1 "МАНАН БУДАН" Цоо шинэ зарна.
Утас: 85828384
- 2 Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна.
Утас: 99144154
- 3 Хуучин номнууд зарна.
Утас: 94640105
- 4 Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30.000 төгрөгөөр зарна.
Утас: 99153637
- 5 Ээж ба хүүхэд ном зарна.
Утас: 99089401
- 6 Сэргэн мандалтын үеийн нэрт зураачдын бүтээлийг өнгөтөөр хэвлэж, орос хэлээр нийтэлсэн Монголд цөөн байдаг уран зургийн ном зарна.
Утас: 99625921
- 7 Official guide of TOEFL TEST 4th edition. Албан ёсны TOEFL тест гаргадаг газраас уг шалгалтад бэлтгэгчдэд зориулан гаргасан GUIDE book-ийн хамгийн сүүлийн хэвлэл. Хэрэглэж байсан мөн дисктэйгээ.
Утас: 99674312
- 8 Түүхийн хэдэн зуун үйл явдлыг Чингисийн үеийн их бага тулалдаанаас авахуулаад Хадгаламж зээлийн хоршооны хэрэг хүртэл бүртгэн багтаасан. Чингисийн үеийн хэдэн алдартныг эс тооцвол То ван, Мянгат гэсэн хоёрхон монгол хүн багтсан байдаг бол энэхүү Britannica 8 төв ширээний нэвтрэхийг толь зарна.
Утас: 88170048

ЦАХИЛГААН БАРАА

- 1 Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар утарна. Тэжээл: 2 AAA батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C)
Утас: 88512938, 96012938
- 2 Модерн загварын ханын цаг (45-55cm) худалдана.
Утас: 96012938, 88512938
- 3 USB гагнуурын алх. Эгшин зуур хална, хөрнө. 480 C градус хүртэл хална.
Утас: 96012938

ХУДАЛДАНА

ПЯНЗ ХУДАЛДАНА. МОНГОЛ, ОРОС, БУСАД.

УТАС: 95777773

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Хүмүүс

Арын албаны ажилсаг хүн

Палкатны үзгээр бичиж, ямбуун дээр бийрээр зурдаг байлаа

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Хүний хувь тавилан бурхнаас зурсан өөрийн зурагтай гэдэг. Эгэл жирийн номын санч бүсгүй нэгэн сонирхолтой хувь зохиолоор кино урлаг тэр тусмаа театрын урлагт хийсэн бүтээсэнээ мөнхлөх завшаан тохиожээ. Тэрбээр “Зүүдэнд ирсэн хонгорхон ижий”, “Үхэж үл болно, Чингис хаан”, “Аравт” зэрэг кино дэлгэцийн 20 орчим уран бүтээлд зургийн даргаар ажилласан нэгэн. Түүний хийж бүтээсэн ажил хөдөлмөрийг төрөөс үнэлж, төрийн дээд Алтан гадас одонгоор энгэрийг нь мялаажээ. Их театрын арын албыг хариуцан яваа УДЭТ-ын Үйлдвэр, техникийн хэлтсийн дарга Н.Батбилэгийг энэ удаагийн “Хүмүүс” буландаа урьж, ярилцлаа. Тэрбээр урлагт заяасан тавиландаа хөтлөгдөн драмын театрын 80 гаруй жүжгийн чимэглэлийн ажлыг гардан гүйцэтгэсэн хөдөлмөрч мөн туйлын даруу хүн юм.

-Та ажил, амьдралын гараагаа номын санчаас эхэлсэн гэлээ. Ямар хувь зохиолоор урлагтай холбогдсон бэ?

-Миний ажил амьдралын гараа номын санч гэсэн сайхан мэргэжлээс эхлэлтэй. Хамгийн анх Архангай аймгийн Батцэнгэл суманд 1980 онд номын санчаар ажилд орсон юм. Тэр үед сумын дарга байсан хадам аавынхаа “ирээдүйн бэрээр” сонгогдчихсон байснаа яахан мэдэх билээ. Ингээд ханьтайгаа танилцаж, цэрэгт байхад нь захидал бичилцээр гэр бүл болсон. Долоон жил сумандаа номын санчаар ажилласан би гэдэг хүн гэр бүлийнхээ хүнийг даган 1987 онд Улаанбаатар хотод анх хөл тавьсан. Хотод ирсэн даруйдаа хуучнаар Офицеруудын ордон байсан цэргийн ансамбльд мэргэжлээрээ ажиллаж эхэлсэн юм. Гэтэл төд удалгүй манай ансамбль зураачгүй болсон



Б.Ганбаяр / ЗГМ©

Микро автобусны жолоочийн ажлыг давхар хашдаг байлаа

учир энэ ажлыг давхар хариуцах үүрэг хүлээлээ. Би багаасаа л зураг зурах дуртай, зураач болох хүсэлтэй хүүхэд байсан юм. Тиймээс надад дуртай зүйлээ хийх нь таалагдаж, хоёр ажлыг торохгүй хийсэн дээ. Ингээд зураачаар цэргийн ансамбльд 12 жил ажиллаж, ажилдаа ч мэргэшээд авсан. Дараа нь зохиолч, найруулагч О.Машбатын байгуулсан “Монголжин” кино студид зургийн даргаар ажиллах санал ирсэн юм. Тус студийн гаргасан “Зүүдэнд ирсэн хонгорхон ижий”, “Золиос”, “Жинжиймаа”, “Вансэмбэрүү” зэрэг кинонд зургийн даргаар ажилласан. Нэгэн удаа ээлжит уран бүтээл болох “Вансэмбэрүү” киноны зураг авалтыг хийхээр Завхан аймаг руу явлаа. Тэр үед тус

кинонд Сувд захирал гол дүрд нь тоглож байсан юм. Тэр үед Сувд гуай намайг харчихаад “Чи манай театрт хэрэгтэй хүн байна. Манайд ирж ажилла” гэж хэлсэн юм. Ингэж л их театрын босгоор 2002 онд алхсан азтай хүн дээ би. Драмын театрт 15 жил ажилласан байна шүү.

-Та их даруу хүн юм. Таны тухай олон хүнээс магтаалын үг сонссон. Их театрт жолоочийн албыг хүртэл хашиж байсан гэж. Энэ тухай дурсахгүй юу?

-Сувдаа захирал манайд ажилд ор гэсний дараахан театрын захирал Д.Цэрэнсамбуу намайг дуудаж уулзан театрын жүжиг чимэглэлийн эрхлэгчээр авахаар болсон. Удалгүй театр микро автобустай болж, тэр автобусны жолоочийн ажлыг давхар хийж байсныг чи дуулсан байна. Нэг үе би гурван ажлыг давхар хашиж байсан удаатай. Үүгээрээ ч бахархдаг.

-Таны үед аливаа уран бүтээлийн хар зургийг хэрхэн гаргадаг байв. Зургийн дарга хүн яг ямар ажлыг гардан хийдэг вэ?

-Миний үед жинхэнэ палкатны үзгээр бичнэ, ямбуун дээр бийрээр зурна гээд бүгдийг

гараар хийдэг байлаа. Тухайн үеийн тоглолтын сурталчилгааг хийхэд жүжигчдийнхээ зургийг харж байгаад л найман метр урт давууг дөрөв хуваагаад л зурдаг байв. Харин одоо хэвлэлтэд өгөөд л болчихно. Зургийн дарга хүн тоглолт, жүжиг гээд бүх нарийн зүйлийн зургийг гардан хийдэг. Жүжигчдийн өмсөх хувцасны зураг, тайзны гоё чимэглэл гээд бүгдийг тухайн найруулагч, зураачийн гаргаж өгснөөр хийх үүрэг хүлээнэ. Ер нь аливаа уран бүтээлийн арын албанд маш том баг, хамт олон ажиллаж байдаг. Ялангуяа

театрын арын алба тайз чимэглэл, гэрэл, дуу, шуугиан, хувцас хэрэглээс өгсүүлээд үүнийг бүтээдэг оёдолчин, мужаан гээд олон хүнийг багтаасан байдаг.

-Таныг дэлгэцийн хэд хэдэн уран бүтээлд дүрээ мөнхөлсөн гэж дуулсан. Алтны дэргэдэх гууль шарладаг гэдэг шиг та жүжигчин болно гэж бодож байв уу?

-Аливаа уран бүтээлд зургийн даргаар явж байх үед ганц нэг уран бүтээлд орох боломж гардаг. Хааяа манай найруулагч, продюссер маань алив нэг ийм туслах дүрд тоглоотох гэдэг юм.

Завтай үедээ орчихно, завгүй бол амжихгүй гэдгээ хэлнэ. Иймэрхүү маягаар “Хуучин сүмийн нууц” киноны олны хэсэгт, “Үүр цайхын өмнө” киноны ядуу бүсгүйн дүр, “Ард аюуш”-ын баян айлын охин гээд мэр сэр бүтээсэн дүрүүд бий.

-Театрын жүжгүүдээс хамгийн хэцүү, чимхлүүр ажил шаардсан тайзны чимэглэлийг та нэрлээч?

-Орсон цагаасаа хойш гэвэл “Тэнгэрийн хүү” жүжгийг хэлнэ. 200 гаруй хүнийг хувцаслах ажлыг хариуцахаас гадна тухайн онд буюу 2005 онд “Үхэж үл болно, Чингис хаан” киноны зургийн даргаар давхар ажиллаж байсан юм. Томоохон хэмжээний түүхэн хоёр уран бүтээл дээр зэрэг ажиллаж байсан тэр үеийг л хэцүү гэх байх. Одоо бодоход яаж амжуулсан юм гэмээр санагддаг шүү. Гэхдээ хамт олны хүч дэмээр бүх зүйл болдог учиртай.

-Тайзны чимэглэл, хувцаснуудыг хадгалдаг уу. Их театр том хэдий ч шинэ уран бүтээл гарах бүрт шинэ хувцас, чимэглэл нэмэгддэг байх. Үүнийг яаж багтаадаг вэ?

-Эрэгтэй, эмэгтэй хувцас тус тусдаа склаттай. Тоглогдож байгаа буюу урын санд байгаа бүхий л жүжгийн хувцаснууд хадгалаастай байдаг. Жүжиг тоглохоор болоход хувцас нь дүр дүрээрээ бүрэн байна. Цэрэндагва ахын хувцас гэхэд муудсан нэг нь актлагаад, эсвэл хуучин хувцас нь байж л байдаг. Дүр нь өөрчлөгдсөн ч гэсэн жүжгийн хувцаснууд тэнд амь бөхтэй оршоор л байдаг. Заримдаа хуучин хувцаснууд хуучны сайхан дурсамж сэдэрдэг шүү. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 03 сарын 29-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Агаарын хөлгийн зорчигчийн үйлчилгээнд кофе, цай, нэг удаагийн хэрэглээний шингэн сүү, элсэн чихэр, жигнэмэг-гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх тендер.

- **Багц 1:** Уусдаг кофе нийлүүлэх
- **Багц 2:** Чанадаг кофе нийлүүлэх
- **Багц 3:** Уусдаг цай нийлүүлэх
- **Багц 4:** Нэг удаагийн хэрэглээний кофены шингэн сүү, элсэн чихэр нийлүүлэх
- **Багц 5:** Жигнэмэг-гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: 08/2017-М

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос: “Агаарын хөлгийн зорчигчийн үйлчилгээнд кофе, цай, нэг удаагийн хэрэглээний шингэн сүү, элсэн чихэр, жигнэмэг-гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх” 5 багц бүхий битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийн иж бүрдлийг албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК-ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- Үүнд:**
- Борлуулалтын хэмжээ сүүлийн 1 жилд: 100 сая төгрөгнөөс багагүй байх,
 - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 80 сая төгрөгнөөс багагүй байх,
 - Санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2015, 2016 он

Тендерийн хамт

- Багц 1-д 1,438,880 төгрөгийн,
- Багц 2-т 2,596,120 төгрөгийн,
- Багц 3-т 2,310,000 төгрөгийн,
- Багц 4-т 1,180,500 төгрөгийн,
- Багц 5-д 378,000 төгрөгийн тендерийн баталгааг тус тус ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 05 сарын 01-ний өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05 сарын 01-ний өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Сонирухон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа дахь, МИАТ ХК –ийн төв байр,
Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө
Утас: 70049860, Факс: 70049919



Шилдэг САНАА

Bloomberg TV Mongolia

“Шилдэг санаа” нэвтрүүлгээр орчин үеийн урлагийн ертөнцийн амин сүнс, цохилох зүрх болсон гайхшруулж, оюун бодлыг сорьж, алмайруулж чаддаг гоц авьяастнуудтай уулзуулдаг. Харин энэ удаагийн дугаарт Америк гаралтай ч Их Британид амьдардаг уран бүтээлч Дэнни Лэйнийг танилцуулах болно. Шил, ган, модоор урладаг түүний баатарлаг бүтээлүүдтэй танилцацгаая!

20:30

11:30 Баасан гараг

09:30 Бямба гараг

18:00 Ням гараг



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Кэмероныг Uber-ийн төлөө лоббидсон хэрэгт буруутгав

Б. Жонсоны төлөвлөгөөг эсэргүүцсэн өргөх бичигт Лондоны 200 мянга гаруй иргэн 2015 онд гарын үсэг зурж байжээ. > 10

Францчуудыг еврогоос салгах Ле Пений төлөвлөгөө

Францчуудын ихэнх нь буюу сүүлийн судалгаагаар 72 хувь нь уг санааг эсэргүүцжээ. > 10

Катар таван тэрбумын хөрөнгө оруулалт амлав

Энэ удаагийн таван тэрбум урьд нь амалсан 10 тэрбум фунт стерлингэд хамаарахгүй, тусдаа хөрөнгө оруулалт. > 10

Залуусын жагсаал Кремлийг бодлогошрууллаа

Мак Седдон

Ерөнхийлөгч Владимир Путин ирэх онд дахин сонгогдоно гэсэн уур амьсгал ОХУ-ын иргэдийн дунд хүчтэй. Гэтэл ням гарагт ОХУ-ыг хамарсан авлигатай тэмцэх эсэргүүцлийн ажиллагаа түүнийг Кремльд дахин зургаан жилээр замаа засахад нь саад их байгааг харууллаа. Сөрөг хүчний удирдагч Алексей Навальный уриалгаар 80 гаруй хотын гудамжинд, ихэвчлэн цагдаагийн хоригийг эс хайхран цугларсан мянга мянган хүний тоо ихэссээр сүүлийн таван жилд ноён Путиний эсрэг өрсөсөн хамгийн том эсэргүүцлийн ажиллагаа болж хувирав.

Владимир Путин ийм юмыг үзэж өнгөрүүлсэн хүн. Тэрбээр 2012 онд Ерөнхийлөгч болж эргэн ирэхдээ ноён Навальный заримдаг тэргүүлсэн эсэргүүцлийн хөдөлгөөнийг нухчин дарж, Крымыг Украинаас салган ОХУ-д нэгтгэх замаар хатуу байр суурьтай, үндсэрхэг үзэлт сонгогчдыг талдаа татсан юм. Албан ёсны санал асуулгаас үзвэл, түүнийг дэмжигчийн хувь хэмжээ 80-аас дээш байгаа нь засгийн эрхийг гартаа атгасан 17 жилийнх нь түүхэнд үнэмлэхүй өндөр үзүүлэлт болж байна.

Ноён Навальныйг дэмжигчид цаашид зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлж чадалгүй өнгөрлөө ч, ноён Путин, түүнийг хүрээлэгчид ОХУ-ын иргэдийн өсөн нэмэгдэж буй дургүйцлийг анхаарч үзэх нь чухал болсныг энэ удаагийн жагсаал цуглаан харууллаа. “Сонгууль хүртэл жилийн хугацаа үлдээд байгаа үед сайны тэмдэг биш. Ирэх оны сонгууль Путиний агуу хүчирхэгийг ойлгуулах сур жавхлантай, ёслол төгөлдөр санал хураалт болох учиртай. Одоо эрх баригчид байдлыг эргэн харахаас



BBM©

аргагүй боллоо” хэмээн урьд нь Кремльд алба хашиж байсан Глеб Павловский тайлбарлав.

Навальныйг даваа гарагт Москвагийн шүүхээс 20 мянган рубль (350 ам.доллар)-ээр торгож, цагдаагийн шаардлагыг биелүүлээгүй гэсэн үндэслэлээр 15 хоног хорих шийдвэр гаргасан.

Ням гарагт болсон жагсаал нь урьд өмнөх эсэргүүцлийн ажиллагаанаас өөр. Оролцогчдын ихэнх нь 25-аас доош насны залуус тул хуучны жагсаал цуглаанд оролцсон байх аргагүй. Эдгээр залуус 2000 оноос хойш тувт Ерөнхий сайд, Ерөнхийлөгч байж ирсэн ноён Путиний засаглалаас өөрийг үзэлгүй өсөж торнисон хүмүүс. Эсэргүүцлийн ажиллагаанд оролцогчид цагдаагийн хоригийг үл хайхран, Кремлийн бат ар тал хэмээн эдүгээ хүртэл тооцож

ирсэн тэр хотуудын гудамжнаа хуран цугларсан юм.

Зарим шинжээчийн тооцоогоор ноён Путиний төрөлх хот Санкт-Петербургд болсон жагсаалд оролцогчдын тоо Москвагийнхаас их байгаа. Жихад нартай олон жил тэмцэж буй, ноён Путинийг 2012 онд дахин Ерөнхийлөгч болоход 92 хувиар дэмжсэн умард Кавказын Дагестаны нийслэл Махачкалад хүртэл иргэд эсэргүүцлээ илэрхийлжээ. “Ичээндээ өчнөөн жил унтсан хүмүүс нойрноосоо сэргээж эхэллээ” хэмээн Дагестаны жагсаалд оролцсон, 22 настай программист Денис Черышев өгүүллээ. Цагдаа нар Дагестанд 156 хүн баривчилсан юм.

Навальный сонгогчидтойгоо цахимаар харилцах чадвар нь Кремлийн эрх баригчдыг бодлого

болгов. Уламжлалт мэдээллийн бараг бүх хэрэгслийг гартаа атгасан удирдлага ОХУ-ын интернэтээс хамааралт шинэ

үеийнхэнд бага нөлөөлж буй бололтой. “Телевиз үздэг хуучин цагийнхан, үзэхээ больсон шинэ үеийнхний хооронд нийтлэг тал

ховор” хэмээн улс төр судлаач Михайл Виноградов тайлбарлаж байна.

Европын холбоо, АНУ-ын Төрийн департамент баривчилгааг буруутгасан ч Кремль жагсаалд оролцогчдыг ноцтой нухчин дарсан зүйлгүй. Цагдаа нар Навальныйн албан байрыг нэгжиж, компьютер, цахим хэрэгслийг нь хураан авсны зэрэгцээ баривчилсан хүмүүстэй жижиг танхайн хэрэг л тулгаж байгаа. Ноён Медведев ч айж эмээгээд байсангүй. Ням гарагийн цаанаар гулгаж өнгөрөөсөн тэрбээр Instagram-д хэлээ гарган, нүдээ ирмэж буй эможи байршуулжээ.

Залуусын эсэргүүцэл нь ноён Путинд дэмжигчдээ идэвхжүүлэхэд нь харин ч тустай зүйл боллоо гэсэн бодолтой хүмүүс цөөнгүй. “Жүжигт зүгээр нэг эсрэг тал хэрэггүй. Энэ жагсаал Навальныйн хир аюултайг бусдад харуулсан хэрэг” хэмээн урьд нь Кремльд ажиллаж байсан Алексей Чеснаков тайлбарлав.

Урьд өмнөх эсэргүүцлийн ажиллагаа нь олны дэмжлэг төдий л авч чадалгүй өнгөрсөн Навальный ОХУ-ын Ерөнхийлөгчид шахалт үзүүлж дөнгөнө гэдэгт ноён Чеснаков эргэлзэж байлаа. “Сонгууль болтол зөндөө хугацаа байна. Ийм балчир залуус сонгуульд саналаа өгөх ч үгүй. Зарим нь угаасаа сонгуулийн насанд ч хүрээгүй” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

FT

Пак Гын Хэгийн байдал хүнд байна

Брайн Харрис, Сон Жун А

Өмнөд Солонгосын прокуроруд авлигын дуулианаас болж төрийн тэргүүний албан тушаалаас огцорсон Пак Гын Хэг уг хэрэгтэй нь холбогдуулан баривчлах тушаал гаргахаар эрэлхийлж байна.

“Асуудал маш ноцтой байна... Буруутгагдаж байгаа хатагтай Пак албан тушаалын хэм хэмжээгээ зөрчиж, компаниудаас санхүүжилт авах эх үүсвэр болгон ашигласан, корпорациудын эрх чөлөөнд халдсан, улсын нууц задруулсан. Түүний тушаалыг биелүүлсэн, дагасан хүмүүс бүгд баривчлагдсан байхад Пакийг баривчлахгүй бол шударга бус” хэмээн даваа гарагт прокурорын мэдэгдэлд дурджээ.

Эл шийдвэрийг өнгөрсөн долоо хоногт хатагтай Пакийг 14 цаг байцаасны дараа гаргасан байна.

Энэ сард тус улсын дээд шүүхээс өнгөрөгч арванхоёрдугаар сард Үндэсний ассамблейн санал хураалтын үр дүнг дэмжих шийдвэр гаргаснаар Өмнөд Солонгосын түүхэнд анхны эмэгтэй Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хатагтай Пакийн прокурорт байцаагдахгүй байх дархан эрх нь дуусгавар болсон. Пак Гын Хэг “зөвлөх удган” гэгдэх дотны найд Чой Сун Шилийн нөлөөнд удаан хугацаанд байсныг эсэргүүцсэн, хэдэн сар үргэлжилсэн жагсаалын дараа парламент ийн шийдсэн. Хатагтай Чойн эзэмшлийн

компаниудад Өмнөд Солонгосын томоохон компаниудыг олон сая ам.долларын хандив өг хэмээн хоёр эмэгтэй үзсэн хуйвалдаж, шахалт үзүүлдэг байсан гэж үзэж буй юм. Түүнчлэн хатагтай Пак Гын Хэг төрийн ямар ч албан ёсны албан тушаал хашдаггүй, аль хэдийнэ хэрэгтэн хэмээгдэж буй хатагтай Чойд Засгийн газрын бодлогын олон баримт материалыг үзэх боломж олгосон гэж буруутгаж буй.

Хэрэв тус улсын дээд шүүх хатагтай Пакийг баривчлах шийдвэрийг хүлээж авах аваас Ерөнхийлөгч асан тэрбээр авлига, эрх мэдлээ урвуулсан, улсын нууц задруулсан хэргээр яллагдах юм.

Өөрийгөө буруу зүйл хийгээгүй хэмээн мэдүүлж буй 65 настай тэрбээр хоёр долоо хоногийн өмнө Ерөнхийлөгчийн хувиар хийсэн сүүлчийн мэдэгдэлдээ “Үнэнийг ухаж байж олох нь гарцаагүй” хэмээн хахирган өнгөөр хэлсэн юм.

Олон сар дэгдсэн дуулианаар Пакийн ойрын шадар туслахууд, мөн Соёлын сайдаар ажиллаж байсан нөлөө бүхий эрхмүүд баривчлагдаад байгаа юм.

Түүнчлэн энэ бүх үймээн самуун хүчээ авсныг илтгэх өөр нэг баримт бол Өмнөд Солонгосын хамгийн хүчирхэг эрхэм, Samsung корпорацийн Де факто тэргүүн Ли Жэ Ёны баривчлал юм. Ноён Ли бизнесийн эрх ашгийн үүднээс хатагтай Чойн компанид Sam-

sung группээс 40 сая ам.доллар хандивласан хэргээр шүүгдэж буй. Харин Ли энэ бүх тулгалтыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Хатагтай Пакийг баривчлахтай холбоотой ямар ч шийдвэр түүнийг дэмжигчдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах нь мэдээж. Түүнээс гадна эсэргүүцэгчдийн ихэнх нь улсын дээд шүүхээс гаргасан албан тушаалаас нь огцруулах шийдвэрийн эсрэг жагсаалд оролцогчид байх юм. Өмнө болсон энэ жагсаалын үеэр гурван хүн амиа алдсан.

Шүүхийн шийдвэрийн улмаас Ерөнхийлөгчийн ээлжит бус сонгууль зарлах шаардлагатай болж, сонгуулийн өдрийг тавдугаар сарын 9-нд товлоосон. Сонгуульд ялсан нэр дэвшигч санал хураалтын маргаашаас л үүрэгт ажилдаа орох юм.

Сөрөг хүчнээ өрсөлдөж буй ахмад улстөрч Мүн Жэ Ин олон долоо хоногийн турш санал асуулгуудыг тэргүүлж буй. FT-ийн өмнө мэдээлж байсанчлан ноён Мүн Жэ Ин үндэсний томоохон конгломератуудад үзүүлдэг Ерөнхийлөгчийн өршөөлийг үгүй болгохоо амласан.

Хатагтай Пак улсынхаа түүхэнд эрүүгийн хэргээр баривчлагдаж буй гурав дахь Ерөнхийлөгч болох магадлал тун өндөр байна. Өмнө нь цэргийн дэглэмийн үед Чун Ду Хван болон Ро Тэ-Ву нар дараагийн залгамжлагчийн шийдвэрээр өршөөгдөж байсан юм.

FT

PC mall SPRING SALE

Hello spring hello savings

ХАВРЫН УРАМШУУЛАЛТАЙ БЭЛЭГТЭЙ ХУДАЛДАА

Бэлгийн сонголттой

INSPIRON 3462

799.900₮

Intel® Celeron® processor
2gb ram, 500GB HDD

Бэлгийн сонголттой

INSPIRON 3567

1.359.900₮

Intel® Core™ i3 processor
4gb ram, 1TB HDD,
AMD R5 M430 2GB DDR3

Бэлгийн сонголттой

INSPIRON 5567

2.129.900₮

Intel® Core™ i5 processor
4gb RAM, 1TB HDD,
AMD R7 M445 4GB GDDR5

Сонголт 1

БҮТЭН ЖИЛИЙН ЭРХТЭЙ

10%ff

BONUS CARD 1.5%

МАНГАЙН СОНГОХ
X4 Drone
Mouse

Сонголт 2

VOUCHER 50.000₮

10%ff

BONUS CARD 1.5%

NOTEBOOK-ЭЭ ХУДАЛДАН АВААД ХҮССЭН БЭЛГЭЭ СОНГОН АВААРАЙ

Intel Inside®. Extraordinary Performance Outside.

Ultrabook, Celeron, Celeron Inside, Core Inside, Intel, Intel Logo, Intel Atom, Intel Atom Inside, Intel Core, Intel Inside, Intel Inside Logo, Intel vPro, Itanium, Itanium Inside, Pentium, Pentium Inside, vPro Inside, Xeon, Xeon Phi, and Xeon Inside are trademarks of Intel Corporation in the U.S. and/or other countries.

☎ 7575-3535 🌐 www.pcmall.mn 📄 PCmallOfficial

Жим Паккард

Дэвид Кэмероны засаг захиргаа, Uber-ийн хоорондох нягт харилцаа нь Лондонд e-hailing буюу цахимаар такси дуудах үйлчилгээний программ хангамжид хатуу зохицуулалт үүсгэхээс зайлсхийх нөхцөл бүрдүүлсэн хэмээн Даунинг Стрит үзэж байгааг хэд хэдэн эх сурвалж уламжлав.

Лондон хотын засаг дарга асан Борис Жонсон тоо нь өссөөр буй, Uber-ийн хөлсний хувийн машинуудтай тэмцэгч, Ситийн хар таксины жолооч нарт зориулан тустай хуулийн төслийг 2015 оны эцсээр боловсруулжээ. Гэтэл зорчигчдыг захиалга өгснөөс хойш унаандаа суух хүртэл доод тал нь таван минут хүлээх болзол тавьдаг байсан зарим маргаантай санаануудаа засаг дарга төсөл танилцуулснаас гуравхан сарын дараа эргүүлэн татсан юм.

Шалтгаан нь хуучин Ерөнхий сайд Дэвид Кэмерон, Сангийн сайд асан Жорж Осборн нар ноён Жонсонд саналаа дахин



BBM©

Кэмероныг Uber-ийн төлөө лоббидсон хэрэгт буруутгав

эргэцүүлээч гэсэн мессеж явуулснаас үүдэлтэй хэмээн Сити холл буюу Их Лондон хотын захиргаанд ажиллаж байсан нэгэн тайлбарлав. “Чөлөөт зах зээл, өрсөлдөөнтэй холбоотой асуудлаар Дэйв, Жорж нараас ихэвчлэн текст мессеж хэлбэрээр өрнүүлсэн яриа болдог байсан” хэмээн тэрбээр өгүүллээ.

Uber-ийн харилцаа холбоо, олон нийтийн бодлого хариуцсан дэд ерөнхийлөгч Рэйчел Уэст-тоун нь ноён Кэмероны зөвлөх байсан Стив Хиллонтэй гэр бүл болсон. Эхнэр, нөхөр хоёр нь Кэмероны хожмын ууган хүү Айвений загалмайлан эцэг, эх нь. Мөн ноён Кэмероны хуучин туслахуудын нэг Дэниель Корски

ч Лондон хотын засаг даргын орлогч асан Изабел Дедрингтэй “дарамталсан” яриа өрнүүлдэг байсан талаар ноён Жонсонд ойр хоёр ч эх сурвалж мэдээллээ. Хатагтай Дедрингийн ажил хэргийн дотно найз уг яриаг “түрэмгий шинж чанартай” хэмээн тодорхойлов. Ноён Корски, Сити холлын

хоорондын харилцааг харуулсан баримтыг Daily Mail сонин мэдээллийн эрх чөлөөний тухай үндэслэлд тулгуурлан Transport for London (тайлбар: Лондон хотын захиргааны мэдлийн тээврийн корпорац)-д тавьсан хүсэлтийн дагуу авч, даваа гарагт нийтэд дэлгэлээ. Уг баримтыг Даунинг стрит үгүйсгэж байгаа.

Uber-т хамаатай асуудлаар Сити холл, Даунинг стритийн хооронд тогтсон харилцааг одоогийн Ерөнхий сайд Тереза Мэй ил болгох нь чухлыг Хөдөлмөрийн намаас парламентад сонгогдсон Вес Стритинг анхааруулав. Тэрбээр бүх намын төлөөлөл оролцдог Парламентын Таксины групп хэмээх бүлгийн

нэвтрүүлэхээр эрмэлзсэн хэрэг” хэмээн уг эх сурвалж өгүүллээ. “Доод тал нь таван минут хүлээлгэхэд хүргэх төлөвлөгөөг эсэргүүцсэн” өргөх бичигт Лондоны 200 мянга гаруй иргэн 2015 онд гарын үсэг зурж байсныг Uber компани хариу тайлбарлаад байна.



Францчуудыг еврогоос салгах Ле Пений төлөвлөгөө

Майкл Стотард

Нам дахь хатуу чиг шугам баримтлагч нараа гонсойлгохгүйгээр, дэмжигчдийнхээ цар хүрээг өргөжүүлэхийг зорьж буй Марин Ле Пен Франц орныг еврогоос хэрхэн аятайхан салгах аргаа эргэцүүлэх боллоо.

Ерөнхийлөгчийн сонгууль эхлэхэд хэдхэн хоног үлдсэн өнөөгийн нөхцөлд Европын нэгдмэл валюттай зах зээлээс гарах санааг Үндэсний фронт намын ихэнх гишүүд дэмжиж байгаа. Гэтэл францчуудын ихэнх нь буюу сүүлийн судалгаагаар 72 хувь нь уг санааг эсэргүүцжээ. Судалгаанд хамрагдагсад еврогоос татгалзах нь францчуудыг улам ядууруулна гэсэн бодолтой байна.

Тавдугаар сарын 7-нд болох сонгуулийн сүүлийн шатанд төвч барууны хүчинтэй өрсөлдөх хатагтай Ле Пен уг нөхцөлд нийцүүлэн бодлогынхоо өнгө аясыг зөөлрүүлэв. Ерөнхийлөгчөөр сонгогдвол Европын холбоо, нэгдмэл валютыг орхих санал хураалтыг эхний зургаан сарын дотор явуулахаар Үндэсний фронтыг үндэслэгч Жан-Мари Ле Пеней охин амалж байна. “Бид ард түмнийхээ үгийг сонсоно” хэмээн хатагтай Ле Пен даваа гарагт Europe 1 радиод өгсөн ярилцлагадаа өгүүлсэн юм.

Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн анхны мэтгэлцээнийг өнгөрсөн долоо хоногт телевизээр дамжуулах үеэр,

хатагтай Ле Пен ард түмний зөвшөөрөлгүйгээр юу ч хийхгүйгээ мэдэгдсэн нь санал хураалт явуулах төлөвлөгөөнийх нь илрэл боллоо.

Ням гарагт Le Parisien сонинд өгсөн ярилцлагадаа тэрбээр орооход бус, хилийн хяналтыг сэргээн тогтоох, үйлдвэрийн ажлын байрыг хилийн чанадад шилжүүлэхийг зогсооход эн түрүүн анхаарахаа тайлбарлав. “Над лав эмх замбараагүй байдал үүсгэх хүсэл алга. Бүхнийг нямтай хийх хэрэгтэй. Германы сонгуулийн дүнг хүлээмээр байгаа учраас евро нь сүүлийн шатанд шийдвэрлэх ажил” хэмээн хатагтай Ле Пен мэдэгдсэн юм. Германы

сонгууль есдүгээр сард болно.

Хатагтай Ле Пен энэ оны эхээр еврог орхих томъёоллоо тайлбарлахдаа хуучин байр сууриа зөөлрүүлсэн юм. Тэрбээр еврогоос бүр өмнө гүйлгээнд байсан, экю буюу Европын валютын нэгжтэй төстэй нийтлэг орооход бус, хилийн хяналтыг сэргээн тогтоох, үйлдвэрийн ажлын байрыг хилийн чанадад шилжүүлэхийг зогсооход эн түрүүн анхаарахаа тайлбарлав. “Над лав эмх замбараагүй байдал үүсгэх хүсэл алга. Бүхнийг нямтай хийх хэрэгтэй. Германы сонгуулийн дүнг хүлээмээр байгаа учраас евро нь сүүлийн шатанд шийдвэрлэх ажил” хэмээн хатагтай Ле Пен мэдэгдсэн юм. Германы

тунхагласан. Хөтөлбөрийнх нь 70 хувь нь Европын холбоо, еврогоос гадна байхад чиглэснийг онцгойлон дурдаж буй хатагтай Ле Пен бүх нийтийн санал хураалтад ялагдал хүлээвэл сайн дураар огцрохоо дахин мэдэгдсэн талаар Europe 1 радио мэдээлж байна.

Францчууд еврогоос хагацах хүсэлгүйг судалгаа харуулж байгааг түүнд анхааруулахад “Би санал асуулгыг анхаарах нь анхаардаг. Гэхдээ зөв мэтгэлцээн болсон цагт хүмүүсийн санаа хувирна гэдэгт эргэлзэх хэрэг юун” хэмээн хариуллаа. “Урьд нь Францад еврогийн талаар хэлэлцүүлэг болж байгаагүй. Учир нь еврог шүүмжлэх нь бурхныг зүхсэнтэй адил байлаа”

хэмээн тэрбээр нэмж өгүүлэв.

Дөрөвдүгээр сард болох сонгуулийн эхний шатанд хатагтай Ле Пен 25 хувийн санал авах урьдчилсан дүн Ифор-ийн судалгаагаар гарсан. Харин сүүлийн шатанд тэрбээр төвч хүчнийг төлөөлж буй Эммануэль Макронтой өрсөлдөж, 40 орчим хувийн санал авна хэмээн шинжээчид таамаглаж байна.

Бизнесийг дэмжигч Монтейний хүүрэллэнгээс гаргасан тооцоогоор еврогоос гарах нь Франц улсад 180 тэрбум евро, хагас сая ажлын байрны хохиорлтой тусна. Үндэсний фронт нам уг тооцоог “дэмийрэл” хэмээн нэрлэжээ.



Катар таван тэрбумын хөрөнгө оруулалт амлав

Женнифер Томпсон

Катар улс ирэх 3-5 жилд багтаж Их Британид таван тэрбум фунт стерлингийн хөрөнгө оруулахаар болсон нь Brexit-ийн дараах нэгдсэн вант улсын ирээдүйд газрын тосоор баялаг, булангийн улс итгэж буйн илрэл боллоо.

Катар нь Qatar Investment Authority (QIA) төрийн хөрөнгө оруулалтын сангаараа дамжуулан Их Британид 40 гаруй тэрбум фунт стерлингийн хөрөнгө оруулсан төдийгүй Shard цамхаг, Natfods сүлжээ дэлгүүр худалдан авч, Лондоны хөрөнгийн биржид хувьцаа арилждаг. Энэ удаагийн хөрөнгө оруулалт нь дэд бүтэц, эрчим хүч, технологи, үл хөдлөх хөрөнгийн салбарт чиглэж байгаа талаар уг мэдээлэлд ойр эх сурвалж тайлбарлаж байна. Хөрөнгө оруулах тухай албан ёсоор мэдэгдсэн нь Их Британийг Европын холбооноос гаргах процессыг лхагаа гарагт эхлүүлэх Тереза Мэйд дэм өгсөн хэрэг болж байна. Ерөнхий сайд болон бусад дээд албаны хүмүүс Brexit-ийн санал хураалтаас хойших есөн сарын хугацаанд Катартай идэвхтэй харилцаа өрнүүлж ирсэн юм.



BBM©

Фунт стерлингийн ханш уналттай уялдан шинэ боломж бүрдэж буйгаас шалтгаалан Лондон хотоос гадна бусад бүсэд хийх хөрөнгө оруулалтад түлхүү анхаарахаар төлөвлөж байгаагаа QIA тайлбарлав. Зөвхөн ойрын 3-5 жилд бус, Их Британийн хэтийн ирээдүйг тооцон хөрөнгө оруулж байгаа тул Brexit-ийн явц булангийн улсын стратегид нөлөөлөх учиргүй талаар Катарын Сангийн сайд Али Шериф аль-Эмади мэдэгдлээ. “Хэтийн ирээдүйн үүднээсээ Их Британийн зах зээлийн эдийн засаг асар их боломжтой гэсэн итгэл бидэнд бий” хэмээн сайд өгүүлсэн юм.

Фунт стерлингийн ханш суларсан нь Их Британи дахь QIA-ийн хөрөнгөд сөрөг нөлөөлж байгааг түүнд анхааруулав. Тэрбээр “Brexit нь бидний хувьд сайн, муу хоёр талтай. Богино хугацаанд хөрөнгө оруулагчийн нүдээр цэгнэвэл хөрөнгийн үнэ унаж байгаа. Гэхдээ бид өөрөөр харж байна. Энд жоохон засвар оруулаад л болчихоор” хэмээн тэрбээр тайлбарлав.

Их Британийн дэд бүтцэд Катарын талаас оруулахаар амалсан

хөрөнгө оруулалт хэрэгжиж чадаагүй тохиолдол бий. Катарын эрх баригчид Хинкли Пойнтын цөмийн цахилгаан станцын шинэ реактор, Темз голын супер цэвэрлэх байгууламжид 10 тэрбум фунт стерлингийн хөрөнө оруулахаар 2013 онд яриа хэлэлцээ өрнүүлж байлаа. Хожим нь Хинкли Пойнтын цахилгаан станцад БНХАУ-ын China General Nuclear компани хөрөнгө оруулагч болсон. Харин Темз голын цэвэрлэх төхөөрөмжийн барилгын ажилд Катарын оролцоо байхгүй.

Гэхдээ ноён аль-Эмади “Бид юм хийнэ гэж амалсан тохиолдолд урт хугацаа шаардагдаж болзошгүй. Энэ таван тэрбум маань урьд нь амласан 10 тэрбум фунт стерлингэд хамаарахгүй, тусдаа хөрөнгө оруулалт” хэмээн тайлбарлав. Лондон, Бирмингемд Катарын Засгийн газар, Олон улсын худалдааны яамтай хамтран зохион байгуулсан хөрөнгө оруулалтын уулзалт чуулган дээр булангийн улсын албаны хүмүүс, компанийн захирлууд уг мэдэгдлийг албан ёсоор сонордуулсан юм.



Эдийн засаг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

"Саадаг" сангуудыг цэгцлэх шаардлага



Сангуудын нийт зардал жил болгоны төсвийн зардлын гуравны нэгийг эзэлж ирсэн.

Б.Ганбаяр / ЗГМ

Тусгай санг хумих бодлого

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Засгийн газрын тусгай сан болгоныг жагсаавал урт дараалал үүснэ. Сангуудын нийт зардал жилийн жилд төсвийн зардлын гуравны нэгийг эзэлж ирсэн. Энэ жишгээр мөн л 2017 оны төсвийн жилд тусгай сангуудаар дамжуулан нийт 2.5 их наяд төгрөгийн зарлага санхүүжүүлэхээр болсон. Үүний дийлэнх хэсгийг нь Нийгмийн даатгалын сангуудын зардал дангаар эзэлж байгаа. Үлдсэн нь бусад сангийн нийт зардал хамаарч байна.

Тусгай сангуудын нийт зардлын 40 гаруй хувийг улсын төсвөөс энэ онд гаргаж байгаа.

Энэ нь ойролцоогоор нэг их наяд төгрөг. Дутсан 1.4 их наяд төгрөгийг тусгай сангуудад төвлөрөх орлого, бусад эх үүсвэрээс бий болгохоор улсын нэгдсэн төсөвт тусгасан юм. Өнөөдрийн байдлаар 20 тусгай сан үйл ажиллагаа явуулж байна. Хүний хөгжлийн санг татан буулгасан бол Эрүүл мэндийг дэмжих сан, Спортыг дэмжих санг шинээр байгуулахаар төсвийн төсөлд тооцсон. Мөн Соёл урлагийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сэргээн ажиллуулахаар болсон юм.

Засгийн газрын тусгай сан нь сайд нарын багцад хамаарч ирсэн. Түүнээс Төсвийн тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв сан, Нийгмийн даатгалын санг бусад хуулиар зохицуулж байна. Сангууд нь Ажлын албатай бөгөөд тэр болгонд урсгал зардал гэж жил бүр тодорхой төсөв баталж буй. Тусгай сангийн тухай хуулийн эрх зүйн орчинг

сайжруулах шаардлагатай гэж Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зүгээс зөвлөж ирсэн. Энэ нь төсвийн ачааллыг бууруулах ач холбогдолтойг тэд хэлдэг юм. Гэтэл өнөөг хүртэл тусгай сангийн тогтолцоонд дорвитой өөрчлөлт гаралгүй өдий хүрлээ.

Өнөөдрийн байдлаар 20 тусгай сан үйл ажиллагаа явуулж байна

Тусгай сангийн тухай хуульд зааснаар Нөөцийн болон Эредэлийн сангаас бусад нь буцалтгүй тусламж, хандив, орлогоор зардлын эх үүсвэрийн хээ зарим хэсгийг бүрдүүлэх ёстой. Гэтэл энэ үүргээ гүйцэт-

гэж байгаа нь 10 хүрэхгүй байна. Тусгай сангуудыг ангилж, төрөлжүүлэх замаар нэгтгэх, зарим санг дансны хэлбэрт шилжүүлэх, төсвөөс гаргах нь оновчтой гэж үздэг эдийн засагч цөөнгүй. Тэдний олонх нь шинээр тусгай сан байгуулахыг хязгаарлах зэргээр зохицуулалт хийх шаардлагатай гэж хэлдэг.

Тусгай санг нэгтгэж, төсвийн багцад оруулснаар төсвийн зарлагад эзлэх хувь, хэмжээ одоогийнхоос багасах юм. Учир нь тусгай сангуудын чиг үүрэг давхцах нь их. Төсвийн орлогыг үр ашигтай зарцуулах шаардлага эдийн засгийн хүндрэлтэй үед улам төрж байна. Тиймээс тусгай санг цөөлөх, чанаржуулах асуудлыг зарим эдийн засагч хөндөж эхэлсэн. Өнгөрсөн онд 18 төрлийн тусгай сан үйл ажиллагаа явуулсан бол энэ онд 20 болж нэмэгдсэн. УИХ-ын зарим гишүүн ийм сан олон болсны уршгаар төсвийн


хөрөнгө тарамдаж байгааг шүүмжилдэг. Нөгөө талаасаа тусгай сан зохицуулалтгүй, хоорондынх нь уялдаа холбоо тааруу аж.

Тусгай сангийн нэг хэсэг нь цаашид хэвээр үлдэж, зарим нь нэгдэж нийлэх бол үлдсэн нь төсвийн бус эх үүсвэрээр санхүүжүүлэх тогтолцоо руу шилжих бололтой. Тэрчлэн төсвийн тусгай данс болсноор одоогийн эрх мэдэл нь хумигдахаас гадна нь үр ашиггүй зардал багасах юм. Ингэснээр тусгай сан нь салбар дундын үйл ажиллагаа руу чиглэх аж. Тусгай сангийн шинэчлэл нь төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах алхам. “Нээлттэй нийгэм форум”-ын энэ оны төсөвт хийсэн судалгаанд “Тусгай сангууд санхүүгийн үр ашиг багатай” гэж дүгнэсэн. Мөн олон сан бий болсноор санхүүгийн ил тод байдал, хяналт алдагдсан талаар дээрх судалгаанд дурдсан нь бий. [ЗГМ]

ЗГМ: ИНФОГРАФИК

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Уул уурхайн боловсруулах үйлдвэр
29%



Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

БАЙР СУУРЬ

ОУВС-тай мөнгөний оновчтой бодлого хэрэгжүүлэхээр тохиролцсон

Б.Мөнх
ЗГМ

Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” болон эдийн засгийн дунд хугацааны төлөвийн талаар ярилцлаа. Мөнгөний бодлогын зөвлөл энэ сард хуралдаж, бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гургасан. УИХ-ын хаврын чуулганаар 2017 оны нэгдсэн төсвийн тодотгол, ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр дээрх хөтөлбөрийг хэлэлцсэний дараа мөнгөний бодлогын төлөвийг цаашид өөрчлөх, эсэхийг эргэн харах нөхцөл бүрдэнэ гэж тус зөвлөл үзэж буй. Энэ цаг үед төв банкны ерөнхийлөгч өөрийн байр сууриа илэрхийллээ.

“Олон улсын валютын сан (ОУВС)-гийн гурван жилийн хугацаатай хэрэгжих

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-г хамрагдах болсон шалтгааныг та хэрхэн тайлбарлах вэ?

–Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн макро эдийн засгийн оновчтой бодлого, ялангуяа төсөв, мөнгөний бодлогын сахилга бат алдагдсан, засаглалын сул тал, эдийн засгийн гадаад орчин таагүй буюу түүхий эдийн үнэ буурсан зэргээс шалтгаалаад манай улсын өрийн тогтвортой байдал алдагдаж, төсөв, төлбөрийн тэнцлийн хүндрэлд орсон. Энэ хүндрэл даамжирсаар Монгол Улс төсвийн алдагдал, гадаад өр төлбөрөө төлөх эх үүсвэрийн дутагдалд ороод байна. Тиймээс үүсээд буй нөхцөл байдлыг арилгах, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор Засгийн газар ОУВС-д “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх хэлэлцээрийг эхлүүлэх хүсэлт тавьсан. Ингээд

бид зургаан сар гаруй хугацаанд хэлэлцээр хийж, өнгөрсөн хоёрдугаар сарын 19-ний өдөр ОУВС-тай Ажлын хэсгийн түвшинд хөтөлбөр хэрэгжүүлэх тохиролцоонд хүрээд байна.

–Хөтөлбөр хэрэгжсэнээр дотоодын эдийн засагт ямар эерэг өөрчлөлт, үр дүн гарахаар байгаа вэ?

–Хөтөлбөрийн хүрээнд бид төсөв, мөнгө, санхүүгийн салбар болон эдийн засгийн өрсөлдөх чадвар, төрөлжилтийг дэмжих үндсэн дөрвөн чиглэлээр бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүний үр дүнд төсвийн алдагдал буурч, өрийн тогтвортой байдал хангагдах юм. Мөн санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар сайжирч, улмаар эдийн засаг цаашид тогтвортой өсөх орчин нөхцөл бүрдэнэ. Энэхүү бодлогын цогц арга хэмжээнд дэмжлэг болгож олон улсын санхүүгийн байгууллагууд, хандивлагч

орнуудаас манай улсад 5.5 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний санхүүжилтийг хөнгөлөлттэй, урт хугацааны зээл хэлбэрээр олгоно. Хөтөлбөрийн бодит үр дүн 2018 оноос эхлэн гарна.

–Тухайлбал, эдийн засаг жилд хэдэн хувиар тогтвортой өсөх боломжтой вэ?

–Бидний ОУВС-тай хамтарч хийсэн төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2018 онд 1.8 хувь, 2019 онд 8.1 хувьд хүрч өсөхөөр байгаа. Төсвийн алдагдал энэ онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 9.4 хувь, ирэх онд 7.3 хувьд, 2019 онд 4.9 хувьд болж буурахаар байгаа. Мөн гадаад валютын нөөц 2019 он гэхэд импортын 6.1 сарын хэрэгцээг хангах буюу 3.5 тэрбум ам.долларт хүрч нэмэгдэх, зээлийн өсөлт ирэх хоёр жилд 10-11.3 хувьд хүрч өсөх эерэг үр дүн харагдах юм.

–Төсвийн алдагдал жил ирэх

тусам багасах нь өрийн дарамт буурна гэсэн үг. Хөтөлбөрийн хугацаанд Монголбанк мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлнэ гэж ойлгож болохгүй. Бид ОУВС-тай мөнгөний оновчтой бодлого хэрэгжүүлэхээр тохиролцсон байгаа. Ингэхдээ хувийн хэвшил, бизнесийн орчныг дэмжсэн, төсвийн бодлоготой уялдаатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл бидэнд бодлогын орон зай гарвал бодит эдийн засгаа дэмжих зорилгоор мөнгөний бодлогыг зөөллөх буюу хүүг бууруулах арга хэмжээ авна. Үүнийг энэ сарын 17-ны өдөр хуралдсан Мөнгөний бодлогын зөвлөлөөс гаргасан мэдэгдлээс харж болно. ▶12

ЗГМ ТОВЧХОН

» НОГДОЛ АШИГ

620

Сая төгрөг. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Ариг гал” хувьцаат компани нэгж хувьцаандаа 17.82 төгрөг буюу нийт 620 сая төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилна.

» ДУУДЛАГА ХУДАЛДАА

0.8

Сая ам.доллар. Банкууд 11.3 сая ам.доллар худалдах, 0.8 сая ам.доллар худалдан авах санал ирүүлсэн ч энэ удаагийн гадаад валютын дуудлага худалдаанд Монголбанк оролцсонгүй.

» АЖ ҮЙЛДВЭР

300

Сая ам.доллар. Нүүрс боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор улсын болон орон нутгийн төсөвт бүх төрлийн татвар хураамж хэлбэрээр жил бүр ойролцоогоор 150-300 сая ам.доллар төвлөрүүлнэ.

» ИПОТЕК

89.8

Мянга. Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.06 их наяд төгрөгт хүрч, нийт зээлдэгчийн тоо 89.8 мянгад хүрэв. Зээлийн 95.7 хувь нь хэвийн, 2.8 нь хугацаа хэтэрсэн, 1.6 нь чанаргүй гэсэн ангилалд оржээ. Нийт зээлийн 99.3 хувь нь төгрөгөөр олгогдсон байна.

» ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Азиа Пасифик секьюритис ҮЦК” компанийн андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор хүчингүй болгов.

» ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв “Аймгуудын өрсөлдөх чадварын 2016 оны тайлан”-г ирэх сард танилцуулна.

» УУЛ УУРХАЙ

2

Тэрбум ам.доллар. Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлж чадвал ойролцоогоор жилд хоёр тэрбум ам.долларыг хайгуулын салбарт татах бололцоотой гэж Ашигт малтмал, газрын тосны газраас мэдэгдлээ.

» ХӨРШ

43.8

Тэрбум юань. Өмнөд хөршийн нүүрсний салбарын орлого өсөв. Тодруулбал, 2017 оны эхний хоёр сард нүүрсний салбарын ашиг 43.8 тэрбум юанд хүрсэн талаар тус улсын Үндэсний статистикийн товчооноос мэдээллээ.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ

Зээлийн картын хуулга-Credit card statement-Банкнаас сар бүр карт эзэмшигчдэд хүргүүлдэг хураангуй мэдээлэл. Үүнд худалдан авалт, төлбөр, шимтгэл хураамж, зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ багтана.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2456.03
Евро	2666.76
Япон иен	22.19
ОХУ рубль	43.15
БНХАУ юань	356.74
БНСУ вон	2.21

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

ОУВС-тай мөнгөний оновчтой бодлого хэрэгжүүлэхээр тохиролцсон

ОУВС-гийн хөтөлбөрийн бодит үр дүн 2018 оноос эхлэн гарна

«11
-Та мөнгөний оновчтой бодлого баримтална гэлээ. Гэтэл Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэр гарсан. Ямар шалтгаан, үндэслэлээр бодлогын хүүнд өөрчлөлт оруулаагүй юм бэ?

-Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөр бид бодлогын хүүг бууруулах эсэх талаар хэлэлцэж, хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Эдийн засагт бодлогын хүүг бууруулах үндэслэл инфляцийн төлөв байдал, эдийн засгийн өсөлт сул байгаа зэргийг харгалзан үзсэн бол байсан. Гэвч эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал буурах, УИХ-аар 2017 оны төсвийн тодотгол, ОУВС-гийн захирлуудын зөвлөлөөр хөтөлбөрийг хэлэлцэх хүртэл хугацаанд бодлогын хүүг хэвээр хадгалахаар шийдсэн.

Эдийн засгийн гадаад орчны тодорхойгүй байдал гэдэгт түүхий эдийн үнэ, эрэлтийг авч үзэж байгаа юм. Манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн зэс, нүүрсний үнэ 2016 оны сүүлийн хагаст дэлхийн зах зээлд өсөж, үүнтэй зэрэгцээд валютын орох урсгал нэмэгдсэн. Энэ нь валютын нөөц, төгрөгийн ам.доллартай харьцах ханшид эерэг нөлөө үзүүлсэн. Гэвч уг үнийн өсөлт нь БНХАУ, АНУ-ын Засгийн газар, төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын нөлөөгөөр хадгалагдах эсэх нь тодорхойгүй байна. Дотоод орчин талаасаа мөнгөний



С.Батсайхан / ЗГМ©

бодлогын зөвлөлийн гишүүдийн олонх УИХ-аар хэлэлцэгдэх төсвийн тодотгол, ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хурлын шийдвэрийг харгалзан үзэж бодлогын шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзлээ.

-Мөнгөний бодлогоос гадна хөтөлбөрийн хүрээнд Монгол-банктай холбоотой ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан бэ?

-Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх гол ажлуудын нэг бол банкны салбарт хөрөнгийн чанарын үнэлгээг олон улсад нэр хүнд бүхий байгууллагаар хийлгүүлэх юм. Энэ нь эрүүл, зохистой засаглалтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц банкны салбартай болоход чиглэгдсэн ажил. Түүнчлэн төв банкны засаглалыг сайжруулах, хараат бус байдлыг хангах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар хөтөлбөрт тусгагдсан байгаа. Уг ажлыг би Монголбанкны Ерөнхийлөгч болсон цагаасаа

хийнэ гэдгээ мэдэгдээд байсан. Төв банкны засаглалыг сайжруулах нь эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой.

-Та 2018 оноос Монгол Улс өсөлт, хөгжлийнхөө замд орно гэж хэлж байсан. Энэ нөхцөл байдал биеллээ олно гэдэг таны байр суурь хэвээр байгаа юу?

-Эдийн засгийн дунд хугацааны төлөвийг эерэгээр харж байгаа. Тиймээс өмнө нь илэрхийлж байсан миний байр суурь өөрчлөгдөөгүй. Ингэж үзэх дөрвөн үндсэн шалтгаан байгаа юм. Өөрөөр хэлбэл, бид 2017 онд дөрвөн том сорилтыг шийдвэрлэж чадсан гэж үзэж байна. Түүний нэг нь, Хөгжлийн банкны өмнөх хуульд тэдний үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг зохицуулах, банкны нөөц сан, эрсдэлийн сангийн зохицуулалтуудыг хийх, хараат бус бие даасан байдлыг хангах, засаглалын тогтолцоог бэхжүүлэх асуудлуудыг сайж-

руулах шаардлагатай байсан. Дээрх зохицуулалтуудыг хийсэн Хөгжлийн банкны тухай шинэчилсэн хуулийн төслийг 2017 оны хоёрдугаар сарын 10-ны өдөр УИХ-аас баталсан. Хөгжлийн банкны хууль, эрх зүйн шинэчлэл нь хөрөнгө оруулагчдын итгэх итгэлийг нэмэгдүүлж, зээлжих зэрэглэл болон гадаад орчны эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байна.

-Хоёр дахь сорилт нь юу байв?

-Хоёрдугаарт, бид гадаад өрийн дарамтыг хөнгөвчлөхөөр чармайж байна. Өөрөөр хэлбэл, энэ сард төлөгдөх Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондыг Засгийн газрын бондоор солих саналыг анхны хөрөнгө оруулагч нарт тавьж, долоон жилийн хугацаатай 600 сая ам.долларын "Хуралдай" бондыг амжилттай гаргасан. Онцолж хэлэхэд, бондыг солих ажлын хүрээнд нэмж 125 сая ам.долларын бондыг шинээр гаргахаар зарлахад худалдан

авах хүсэлтийн хэмжээ 3.3 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдын бидэнд итгэх итгэл, Монгол Улсын дунд хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр харж буйг илтгэж байгаа юм.

Эдийн засгийн дунд хугацааны төлөвийг эерэгээр харж байна

-Гурав дахь нь Хятадын Ардын банктэй байгуулсан своп хэлцэл үү?

-Тийм ээ. Монголбанк Хятадын Ардын банк хооронд нэлээд хэдэн сарын хугацаанд үргэлжилсэн хэлцэлийн үр дүнд своп хэлцлийн хугацааг гурван жилийн хугацаатай буюу 2020 он хүртэл сунгахаар тохиролцлоо. Түүнчлэн своп хэлцлийн хэмжээг нэмэгдүүлэх боломж ч байгаа. Дөрөвдүгээрт, 2018 оны нэгдүгээр сард төлөгдөх 500 сая ам.доллар, зургадугаар сард төлөгдөх 160 сая ам.долларын Засгийн газрын бондын төлбөрийг төлөх асуудлыг ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд шийдвэрлэх боломжтой болсон.

-Манай улс эдийн засаг өндөр өсөлттэй жилүүдэд үсрэнгүй хөгжлийн замдаа орлоо гэж бид ярьдаг байсан. Гэвч хоёр ч удаа эдийн засгийн хүндрэл, уналтад ороод байна. Цаашид энэ байдал давтагдахгүй байх уу?


-Та маш чухал асуудлыг хөндөж байна. Таны хэлж буй хугацаанд Монгол Улсад уул уурхайн салбарын экспортын орлогоос хамаарсан төсөв, мөнгөний мөчлөг дагасан

бодлого явж ирсэн. Энгийнээр хэлбэл, бид мөнгөтэй болсон үедээ хэт үрэлгэн зарцуулж, хуримтлал үүсгэдэггүй, хомстсон үедээ хэмнэх горимд шилждэггүй зарчмаар явж ирлээ. ОУВС-тай хийсэн хэлцэлээр төсвийн сахилга бат, зохистой засаглал, бодлогын голлох байгууллагуудын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх ажлууд үндсэндээ хийгдэнэ. Ингэснээр бидэнд дунд болон урт хугацаанд тогтвортой бодлого хэрэгжүүлэх боломж нээгдэж буйгаа нь эдийн засгийн болон санхүүгийн хямралд өртөхгүй байх хөшүүрэг болно. Энэ ажлыг Монголбанк өөрөөсөө эхэлнэ. Энэ он гарсаар Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийг 2017-2019 оны хооронд хэрэгжүүлэхээр баталлаа. Уг хөтөлбөр хууль, эрх зүйн орчинг сайжруулах, засаглал, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийг боловсронгуй болгох, дэвшилтэт технологи, арга ажиллагааг бэхжүүлэх гэсэн үндсэн таван чиглэлд тулгуурлаж байгаа юм.

-Энэ онд болон цаашид эдийн засаг тогтвортой байх боломжтой гэж ойлгож болох уу?

Тиймээ. Эдгээр тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэснээр манай улсын өрийн дарамт арилж, 2017 онд эдийн засгийг тогтворжуулах төсөв, мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлэх орон зай үүсч байгаа юм. Эдийн засгийн гадаад орчин талдаа ч гэсэн бидэнд түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой эерэг өөрчлөлтүүд гарлаа. Тэгэхээр миний өмнө хэлсэнчлэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 оноос сэргэж, 2019 онд найман хувьд хүрч өсөх бүрэн боломжтой. [ЗГМ]

Хөрөнгийн биржийн индекс 0.32 хувиар өсөв



MSE ALL

Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй 20 хувьцаат компанийн нийт 35,602 сая ширхэг хувьцаа арилжжээ. Хөрөнгийн биржийн индекс энэ өдөр 817.14 нэгж болж, 0.32 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.41 их наяд төгрөг боллоо.

Ханшийн өөрчлөлтийн хувьд 15 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орсон байна. Үүнээс "Авто импекс" компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 14.8 хувиар өссөн бол "Ремикон"-ийнх хамгийн өндөр буюу 1.4 хувиар уналаа. Энэ өдөр Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 2,220 ширхэг үнэт цаас арилжжээ. [ЗГМ]

Засгийн газрын МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	59.93	▲ +1.54%	3/28/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.03	▼ -14.29%	3/28/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	23.75	▼ -3.06%	3/28/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.023	▼ -4.17%	3/28/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	3/28/2017
PROPHESY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.55	▼ -5.33%	3/28/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.08	▲ +0.74%	3/28/2017
SOUTHGObi RESOURCES	SGQ	TSX	CAD	0.395	▲ +12.86%	3/28/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▲ +2.44%	3/28/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	-0.02	▼ -3.08%	3/28/2017

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1252.83	▼ -0.09%	3/28/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	973.5	▲ +0.11%	3/28/2017
МӨНГӨ	SIA	унци	18.08	▼ -0.15%	3/28/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	262.15	▼ -0.4%	3/28/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	87.91	▼ -0.18%	3/28/2017
WTI ТОС	CLA	баррель	47.99	▲ +0.54%	3/28/2017
БРЕНТ	COA	баррель	50.99	▲ +0.47%	3/28/2017
БЕНЗИН	XBA		162.17	▲ +0.17%	3/28/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.031	▼ -0.69%	3/28/2017
НҮҮРС (NYMEX)	OZA	тонн	336.55	▲ +0.21%	3/28/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	80.85	▲ +0.5%	3/28/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	17.7	▼ -0.06%	3/28/2017
БУДАА	RRA	центнер	9.8	▼ -0.05%	3/28/2017
БУУДАЙ	WA	бушель	421.25	▲ +0.12%	3/28/2017
КАКАО	CCA	тонн	2150	▲ +0.89%	3/28/2017
КОФЕ	KCA	фунт	139.2	▲ +1.16%	3/28/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

Тэнцвэртэй мэдээллийг Танд

FTSE | The New York Times

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АПУ ХК	APU	339.58	▲ 0.66%	3/29/2017
ГОВЬ ХК	GOV	12000	▲ 0.25%	3/29/2017
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	20500	▲ 0%	3/29/2017
СҮҮ ХК	SUU	135.26	▲ 2.47%	3/29/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	20000	▲ 0%	3/29/2017
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2000	▲ 0.10%	3/29/2017
БАГАНУУР ХК	BAN	1750	▼ -0.91%	3/29/2017
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	40800	▲ 2%	3/29/2017
ДАРХАН ХҮНС ХК	DHU	4900	▲ 0.22%	3/29/2017
Э-ТРАНС ЛОЖИМТИКС ХК	ETR	96	▲ 0%	3/29/2017
ЖЕНКО ТҮР БЮРА ХК	JTB	54	▲ 5.88%	3/29/2017
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	MDR	401	▲ 0.25%	3/29/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	369	▲ 1.10%	3/29/2017
РЕМИКОН ХК	RMC	46.33	▼ -1.40%	3/29/2017
ШИВЭЭ ГОВЬ ХК	SHG	2000	▲ 0%	3/29/2017
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2190	▲ 0%	3/29/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	3902	▲ 0.26%	3/29/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО	
NASDAQ COMPOSITE	CCMP	5840.375	+11.64	▲ +0.2%	3/28/2017
DAX INDEX	DAX	11996.07	-68.2	▼ -0.57%	3/28/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15506.22	+63.55	▲ +0.41%	3/28/2017
S&P ASX 200	AS51	5821.234	+74.54	▲ +1.3%	3/28/2017
S&P 500	INX	2341.59	-2.39	▼ -0.1%	3/28/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3249.261	-17.69	▼ -0.54%	3/28/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20550.98	-45.74	▼ -0.22%	3/28/2017
TOP 20	MSETOP	12292.71	+34.65	▲ +0.28%	3/28/2017
FTSE 100	UKX	7293.5	-43.32	▼ -0.59%	3/28/2017
HANG SENG	HSI	24320.12	+126.42	▲ +0.52%	3/28/2017
NIKKEI 225	NKY	19174.14	+188.55	▲ +0.99%	3/28/2017